4. Шинжээчид тус бүртээ үнэлсэн тохиолдолд шинжээчдийн игийн нэгдсэн үнэлгээ болон дүгнэлтийг төсөл тус бүрээр гаргаж рын үсэг, тамга тэмдэг дарсан байна.

5. Шинжээчид нь гаргасан үнэлгээ, дүгнэлтээ Төрийн өмчийн зорооны хуралдаанаар хэлэлцүүнэ. Төрийн өмчийн хороо нь дүгнэлтийг үндэслэлтэй гэж үзвэл батлах, үндэслэлгүй болон хууль

зөрчсөн гэж үзвэл дахин шинжилгээ хийлгэх шийдвэрийн ал нэгийг гаргана.

55 дугаар зүйл. Хувьцаа, ногдол хувь гарган  
хувьчлах

1. Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компаний хэлбэрт оруула хувьцаа, ногдол хувийг нь худалдах замаар хувьчилж болно. Эн тухай шийдвэрийг Төрийн өмчийн хороо гаргана.

Эдийн засаг нийгмийн хэрэгцээ шаардлагын үүднээс төр зари хувьцааг нийтэд санал болгохгүй, өөрийн өмчлөлдөө авч үлдэ төрийн өмчийн оролцоотой этгээд үүсгэж болно.

2. Төрийн өмчит үйлдвэрийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаа өөрчлөн зохион байгуулах ажлыг Төрийн өмчийн хороо эрхэлж Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан үүсгэ байгуулагчийг төлөөлсөн үүргийг гүйцэтгэнэ.

3. Төрийн өмчийн хороо нь хувь нийлүүлэгчдийн зохио байгуулах хурлыг хувьцаа, ногдол хувь нь зохих журмын дагу борлогдож дууссанаас хойш 3 сарын дотор зохион байгуулж өөрий хариуцаж байсан эрх, үүргийг шинээр байгуулагдсан хуулий этгээдийн удирдлагад шилжүүлднэ.

56 дугаар зүйл. Төрийн өмчлөлийн хувьцаа, ногдол  
хувийг хувьчлах, бусад этгээдийн  
өмчлөлд шилжүүлэх

1. Энэ хуулийн 55 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар компан болон өөрчлөгдсөн төрийн өмчит үйлдвэрийн газрын болон төрий өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хувьцаа, ногдс хувийг Төрийн өмчийн хорооны шийдвэрээр чөлөөтэй, эсхү багцалсан хэлбэрт оруулан энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаа биржээр болон энэ хуулийн 38-45, 46-54, 58 дугаар зүйлд заасн дагуу биржийн гадуур арилжиж худалдана.

2. Хувьцааг биржээр худалдахад дор дурдсан дараалал, журма баримтална:

1/ хувьцааг биржээр арилжаалахад Төрийн өмчийн хорк хувьчлагдах үйлдвэрийн газрын хөрөнгийг үнэлэн, гаргах хувьцаан хэлбэр, тоо хэмжээ, худалдах анхны үнэ, багцлах бол түүний хэмжэ зэргийг тогтоон Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд арилжи тухай шийдвэрийг гаргана.

Мөн хувь нийлүүлсэн байгууллага дахь төрийн өмчлөлийн хув цааг энэ хэлбэрээр арилжиж болно;

2/ хувьцааг биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны тухи хуульд заасан журмын дагуу явуулна.

3. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмч лөлийн ногдол хувийг худалдахад Нөхөрлөл, компанийн тухи

улийн 91 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тухайн улийн этгээдийн бусад өмчлөгчдийн /гшлүүдийн/ саналыг авна.

4. Үндэсний аюулгүй байдал, стратегийн ач холбогдолтой төрийн чийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хувьцааг далдах талаар Засгийн газар тусгайлан журам тогтоож болно.

57 дугаар зүйл. Хамтарсан үйлдвэрийн газар байгуулах замаар хувьчлах

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүхэлд нь, хүл зарим хэсгийг нь хувь нийлүүлж гадаад, дотоодын хөрөнгө уулагчийн хөрөнгөтэй нийлүүлж хамтарсан үйлдвэр байгуулах маар хувьчилж болно. Ийнхүү хувьчлахдаг:

1/ төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн зарим хэсэг гвьцаа, ногдол хувь/-ийг хөрөнгө оруулагчид худалдах;

2/ төрийн өмчит хуулийн этгээдийг шинэчлэх, өргөтгөх зорил-эр бусад этгээдийн хөрөнгө нэмж оруулах;

3/ төрийн өмчит хуулийн этгээдийн өрийг бусад этгээдэд талдан барагдуулж уг этгээдэд өр тэлсэн хэмжээгээр төрийн чийн хувьцаа эзэмшүүлж тус тус болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аль ч тохиолдолд талууд өр загдуулах, хувьцаа эзэмшүүлэх гэрээ байгуулж, түүнд хувь ний-длэх хөрөнгөө харилцан тохиролцсоны үндсэн дээр үнэлж, тлвэртлэл, түүнийг удирдах үйл ажиллагааны талаар харилцан гээх эрх, үүргийг Нөхөртлэл компанийн тухай хууль, эсхүл Монгол сын олон улсын гэрээний дагуу тусгана.

3. Хамтарсан үйлдвэрийн талаархи бүхий л харилцаанд төрийн чийн төлөөлөгчийн үүргийг Төрийн өмчийн хороо, түүний алсон этгээд гүйцэтгэнэ.

58 дугаар зүйл. Удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах

1. Төрийн өмчит хуулийн этгээдийг удирдах үйл ажиллагааг менежмент/ удирдлагын өндөр мэргэшил, дадлагатай, үйлдвэр-нийг үр ашигтай зохион байгуулах үр чалвартай, хувийн өмчит лийн этгээд, хувь хүнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүж гно.

2. Менежментийн гэрээгээр ажиллах этгээд нь гэрээнд заасан г өөрийн багийг бүрдүүж болно.

3. Менежментийн гэрээг төсөл сонгон шалгаруулалтын үндсэн р хуульд өөрөөр заагаагүй бол 3 хүртэл жилийн хугацаагаар ггээр байгуулна.

4. Гэрээнд үүргийн тухай болон ажил гүйцэтгэх гэрээний тухай гэний хуульд тодорхойлсон заалтуудыг баримтлахаас гадна авхь болалыг заавал тусгана.

1/ удирдах үйл ажиллагааг гүйцэтгэгч /менежер/ этгээдээ үйлдвэрийн зохион байгуулалт, технологийн үйл ажиллагааг өөрчлөн байгуулах болон үр ашиг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ хэрэгжүүлэх хугацаа, үе шат, дүгнэж үнэлэх шалгуур үзүүлэлт журам;

2/ гэрээгээр ажиллах этгээдийн налин хөлс, урамшил;

3/ гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд төрийн өмчийн эд хөрөнгөөс хувьчлан өгөх хэмжээ, хэлбэр, үнэ;

4/ гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйд хүлээлгэх хариуцлага, учруулсан хохирлыг нөхөн төлөх хэлбэр, хэмжээ, түүнд барьцаалах хөрөнгө.

5. Менежментийн гэрээний аргыг төрийн өмч давамгайлса хувьцаат болон хамтарсан хуулийн этгээдийн төрд ногдох хувьцаа худалдах нөхцөлөөр хэрэглэж болно. Энэ тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөлтэй зөв шилцөж тохирсон байна.

59 дүгээр зүйл. Давуу эрхтэй тусгай төрлийн хувьцаа гаргах замаар хувьчлах

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүрэн хэмжээгээр хувьчлах боловч үйлдвэрлэлийн зарим үйл ажиллагаан төрөөс тодорхой хугацаанд хяналт тавьж зохицуулах шаардлагата бол ногдол ашиг авахгүй зөвхөн саналын эрхтэй тусгай хувьцаа эзэмших замаар оролцож болно.

2. Төр ийм төрлийн хувьцаа гаргаж өөрөө эзэмших, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд, хугацаа зэргийг тухайн хуулийн этгээдийг хувьчлах үед Төрийн өмчийн хорооноос нийтэд зарла мэдээлнэ.

60 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгаж эд хөрөнгийг хувьчлах

1. Дамдуурсан буюу техник, технологи нь хоцрогдсон, цаашир өөрчлөн шинэчилсэн ч эдийн засгийн үр ашиггүй нь тогтоогдсо төрийн өмчит үйлдвэрийн газрыг Засгийн газрын шийдвэрээр тата буулгаж өрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг хувьчил болно.

2. Татан буулгах хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого хий дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн эн хуулийн 30 дугаар зүйлд зааснаар бусад шилжүүлэх, эсхү дуудлагаар худалдах ажлыг Засгийн газрын шийдвэрийг үнэслэ Төрийн өмчийн хороо эрхлэн гүйцэтгэнэ.

61 дүгээр зүйл. Өмч хувьчлан авагч этгээдтэй байгуулах гэрээ

1. Хувьчилсан эд хөрөнгийг өмчлөгч этгээдэд шилжүүлэхийг

өмнө Төрийн өмчийн хороо шинэ өмчлөгчтэй эд хөрөнгө хувьчилсан тухай гэрээ байгуулна.

2. Гэрээнд дараахь нөхцөлийг заавал тусгасан байна:

1/ төрийн өмчийг хувьчилсан болон хувьчилж авсан этгээдийн нэр, орших газар, хаяг бүртгэлийн дугаар;

2/ хувьчилсан эд хөрөнгийн нэр төрөл, нэг бүрийн болон нийт үнэ, түүнийг төлөх хугацаа, хэлбэр;

3/ өмчлөх эрхийн гэрчилгээ олгох нөхцөл;

4/ хувьчилсан эд хөрөнгийг шинэ өмчлөгчид шилжүүлэн өгөх буюу хүлээн авах газар, хугацаа, журам, хүлээн авах, өгөх ажлыг гүйцэтгэх этгээд, тэдгээрийн эрх, үүрэг;

5/ хувьчлан авсан эд хөрөнгийн ашиглалтын талаар өмчлөгч төрийн өмнө үүрэг хүлээсэн бол уг үүрэг, хариуцлага, түүнчлэн эд хөрөнгийг хүлээн авах, хүлээлгэн өгөх хугацаа, журам зөрчсөнийг сариуцлага.

3. Гэрээнд хуульд харцлахааргүй бусад нөхцөлийг тохиролцон зааж болно.

4. Энэхүү гэрээнд хөрөнгө хүлээлгэн өгсөн тухай акт-болон тодорхой төсөл хэрэгжүүлэх болзолтой авч байгаа бол уг баримт бичгийг заавал хавсаргана.

62 дугаар зүйл. Хувьчлалыг хүчингүйд тооцох үндэслэл

1. Дараахь үндэслэлийн аль нэг нь байвал хувьчлалыг хууль бус гэж үзэж хүчингүй болгоно:

1/ Улсын Их Хурлын буюу Засгийн газрын баталсан жагсалтад зроогүй объектыг хувьчилсан;

2/ тодорхой объектыг Төрийн өмчийн хорооны зохих шийдэргүй хувьчилсан;

3/ дуудлага худалдааны болон уралдаант шалгаруулалтын журам өрчсөн;

4/ хувьчлан авагч эд хөрөнгийн үнэ, хууль, гэрээнд заасан бусад өлбөрийг гэрээний хугацаанд төлөөгүй буюу төлбөрийг хууль ёсаар хийсэн;

5/ нэрлэсэн хэмжээнээс доогуур үнээр худалдсан буюу хувьчлахыг зөвшөөрөөгүй эд хөрөнгө оролцуулан авсан, өгсөн;

6/ хувьчлан авагчид нь хуульд зааснаас илүү хөнгөлөлт, давуу эрх олгосон;

7/ хувьчлан авагч өмч хувьчлан авсан тухай гэрээгээр хүлээсэн үргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй;

8/ хувьчилсан эд хөрөнгийн үнийг төлөхөд хуулиар хориглосон х үүсвэрийг ашигласан;

9/ өөр хэлбэрээр энэ хууль болон бусад хууль зөрчсөн.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлтээр хувьчлалыг

хүчингүйд тооцох болон хөрөнгийн хохирлыг хэрхэн арилгах шийдвэрийг Төрийн өмчийн хороо гаргана.

3. Хувьчлал хүчингүй болсон тохиолдолд Төрийн өмчийн хороо уг зөрчлөөс үүссэн хохирлыг арилгах, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авч, цаашид уг эд хөрөнгийг хэрхэх тухай шийдвэр гаргана.

4. Энэ зүйлд зааснаар Төрийн өмчийн хорооны гаргасан шийдвэрийг сонирхогч этгээд эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

63 дугаар зүйл. Хувьчилсан өмч хөрөнгийн үнийг төлөх хөрөнгийн эх үүсвэр

1. Хувьчилсан эд хөрөнгийн үнийг хувьчилж авсан этгээд өөрийн болон хууль ёсоор авсан дотоод, гадаадын эзэлийн мөнгөн хөрөнгөөр /үнэт цаасаар/ төлнө.

2. Үнийг төлөхөд зориулж хувьчлалд зориулсан сан болон бусад эх үүсвэрээс хуульд заасан нөхцөл, журмын дагуу Засгийн газар, өмчлөгчид зээл олгож болно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад хөрөнгийн эх үүсвэрийг хувьчилж байгаа эд хөрөнгийг худалдан авахад төлбөрийн хэрэгсэл болгохыг хориглоно.

64 дүгээр зүйл. Хувьчлалын орлого

1. Төрийн өмчийг хувьчлах явцад авсан бүх төрлийн хураамж, хувьчлагдсан эд хөрөнгийн үнэ, энэ зориулалтаар бусдаас төрд өгсөн хандиваас хувьчлалын орлого бүрэлдэнэ.

2. Хувьчлалын орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулан зөвхөн хөрөнгө оруулалтын зориулалтаар зарцуулна.

65 дугаар зүйл. Хувьчлалын тайлан

1. Төрийн өмчийн эд хөрөнгийн хувьчилсан тухай бүр хувьчлал эрхлэн явуулсан албан тушаалтан хувьчлалын тайлан бичиж Төрийн өмчийн хорооны хуралдаанд оруулна. Тайлан бичиг загварыг Төрийн өмчийн хороо батална. Тайланд дараахь зүйлийг тусгана:

- 1/ хувьчилсан эд хөрөнгийн тооллого, үнэлгээ хийсэн байдал;
- 2/ хувьчлах талаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр;
- 3/ хувьчлах ажиллагаа явуулсан дүн, эд хөрөнгийг худалдсан үнэ, төлбөр хийсэн байдал;
- 4/ байгуулсан гэрээ;
- 5/ шинэ өмчлөгчид эд хөрөнгийг хүлээлгэн өгсөн байдал.

2. Тайланд гэрээ, хөрөнгийн жагсаалтыг тус тус хавсаргана. Тайлан нь төрийн өмчийн тухай эд хөрөнгийг хувьчилсан тухай нотлох хуулийн үндсэн баримт бичиг бөгөөд түүнийг Төрийн өмчийн хорооны хуралдаанаар хэлэлцэж батална.

3. Баталсан тайланг зохих журмын дагуу архивт тусгай сав хөмрөг болгон шилжүүлнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалт, бүртгэл, тооцоо

66 дугаар зүйл. Хяналт шалгалтын тогтолцоо

1. Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, шиглалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалт нь Үлсмын Их Хурал, Засгийн газраас тавих ерөнхий хяналт, Төрийн янзан шалгах хороо, Сангийн яамнаас хэрэгжүүлэх мэргэжлийн хяналт шалгалт, Төрийн өмчийн хорооны болон хуулийн этгээдийн дотоодын хяналт шалгалтаас бүрдэнэ.

2. Төрийн өмчийн хороо болон эрх бүхий бусад байгууллагын ахицгаар төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хөндлөнгийн магадлан шалгалт хийлгэж болно.

3. Төрийн өмчийн хороо энэ талаархи хууль болон Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах үндсэн дээр өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад гүйцэтгэлийн болон баримтын байцаан шалгалт хийх, бүртгэлээр хяналт тавих зэргээр өмчийн адгалалт, хамгаалалтад тавих системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

4. Сангийн яам нь Төрийн өмчийн хороогой хамтран төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аримтын иж бүрэн шалгалтыг 2 жил тутам нэгээс доошгүй удаа явал хийх ба шалгалтын дүнг хамтран хэлэлцэж шаардлагатай арга мжээ авна.

5. Эрх бүхий байгууллагууд тус тусын эрхлэх ажлын хүрээнд өмч имгаалах асуудлаар төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалтад санхүүгийн гэнэтийн сонгон шалгалт хийж болно.

67 дугаар зүйл. Дотоодын хяналт шалгалт

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өлөр тутам тавих дотоодын шалгалтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.

2. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан идэгч хариуцна.

68 дугаар зүйл. Эд хариуцагч

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч дгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн йлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг хий этгээдийг эд хариуцагч гэнэ.

2. Эд хариуцагчийн жагсаалт, эд хариуцагчаар сонгон авах журам, эд хариуцагчтай байгуулах гэрээний ерөнхий нөхцөлийг Засгийн газар тогтооно.

69 дүгээр зүйл. Төрийн өмчит хуулийн этгээдийн нягтлан бодох бүртгэл, бүртгэл тооцоо

1. Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийг баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож Сангийн яаманд тушаана.

2. Заавал хөтлөх нягтлан бодох бүртгэлийн нийтлэг маягтаас гадна төрийн өмчийн хуулийн этгээдэд хөтлөгдвөл зохих мэдээ, тайлангийн маягт, аргачлалыг Төрийн өмчийн улсын хороо батламь мөрдүүлж болно.

3. Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгээр захирал томилно.

70 дугаар зүйл. Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн үлдсэн хөрөнгө, үнэт цаас мөнгөн хөрөнгийн тооллогыг дотоодын тооллого, улсын тооллого гэж хоёр хуваана.

2. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлаглана:

1/ үлдсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга утралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/;

2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1,12 дугаар сарын 1-нээс/;

3/ дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд 1 удаа /улирлын эцсийн сарын 25-наас/;

4/ мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал болон жижиглэн худалдаалах газар /дэлгүүр, цайны газар, ресторан, бар, зочид буудал гэх мэт/-т байгаа бараа, сав, боодлыг сар бүр /сар бүрийн 1-нээр /;

5/ ажлын болон өсвөр, үржил, тэжээлд байгаа мал, амьтдыг жилд 1 удаа /12 дугаар сарын 15-ны/;

6/ гааль, худалдааны, онцгой албан татвар, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын жилийн бусад татвар хураамжийн талаар төвлөрсөн болон орон нутгийн төсөвтэй хийх тооцоог улиралд эзвэл 1 удаа хийх;

7/ банкны байгууллагаас бүх төрлийн харилцах дансны хуулгыг

авч бүрээ дансны гүйцээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг батлах.

3. Дотоодын тооллогын тайлан тэнцлийн дүнг Төрийн өмчийн хороо санхүү, статистикийн байгууллагатай хамтран улсын хэмжээгээр нэгтгэн гаргаж, дутагдсан эд хөрөнгийг нөхөн төлүүлэх, илүүдэл болон шашид ашиглах боломжгүй болсон үндсэн эд хөрөнгийг шилжүүлэх, борлуулах, устгах зэрэг шаардлагатай арга хэмжээ авч Засгийн газарт тайлагнаана.

4. Үндсэн хөрөнгийн, шаардлагатай гэж үзвэл эргэлтийн хөрөнгийн улсын үзлэг тооллогыг Төрийн өмчийн хороо эрхлэн 4 жилд 1 удаа Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн ГҮ улиралд багтаан явуулна.

71 дүгээр зүйл. Эд хөрөнгийн тооллогын бэлтгэлийг хангах

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараахь бэлтгэл хангасан байх дүртэй:

1/ үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн заримт бичгийг гүйцээл бүрдүүлсэн байх;

2/ бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг нэгтгэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх;

3/ агуулахад байгаа түүхий эд, материал, бэлэн бүтээгдэхүүн, салбэг хэрэгсэл зэрэг эд хөрөнгийг төрөлжүүлж, хураалт, халгалалтыг нэгжлэсэн байх;

4/ үйлдвэрлэлийн салбар, нэгжилд байгаа хэрэгцээнээс илүү үндсэн хөрөнгийн зүйлс, түүхий эд, нигас боловсруулсан зүйл, бэлэн бүтээгдэхүүн ашиглаж болох хоёрлогч түүхий эд зэргийг агуулахад шилжүүлж гологдол болсон бүтээгдэхүүнийг шийдвэрлэсэн, гүйцэтгэсэн ажлын журнал хөтлүүлж, дуусаагүй ажлын хөрөнгө оруулалт нь барилга утралтын ажлын хэмжээг тодорхойлсон байх ;

5/ мал, амьтныг эзэмшигч бүрээр тоолоход бэлтгүүлэх;

6/ тооллогод хэрэглэгдэх хэмжих багаж, хэрэгслийг шалган баталгаажуулж бараа материалын үнийн болон хэвийн хорогдлын тормын жагсаалтыг үйлдсэн байх;

7/ өмнөх тооллогоор тайлан тэнцлээс хасахаар шийдвэрлэсэн үндсэн хөрөнгө, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн, барааг худалдах, устгах зэргээр бүрэн шийдвэртүүлж үр дүнг бүртгэлд тусгасан байх;

8/ өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх.

72 дугаар зүйл. Тооллогын комисс, түүний эрх,  
үүрэг

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна.

2. Тооллогын комисс байгуулах шийдвэрт тооллого эхлэх, дуусгах хугацааг тооллого явуулах салбар, нэгж бүрээр заасан байна.

3. Улсын тооллогын үед тооллогыг зохион байгуулах, тооллогын комиссын ажилд хяналт тавьж, туслах төлөөлөгчдийг Төрийн өмчийн хороо томилж ажиллуулна.

4. Тооллогын комисс дараахь үүрэгтэй:

1/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж дуусгах;

2/ тоолсон эд хөрөнгийн үнийн бэлтгэн нийлүүлэгчийн дагалдаж баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж тооллогын бүртгэлд бичих;

3/ агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөглөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдээ тоол-логоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

5/ эвлэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхийг эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих.

5. Тооллогын комисс дараахь эрхтэй:

1/ тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас эд хөрөнгийг орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтуудыг хүлээн авсан эсэхийг шалгах;

2/ тооллого явуулахын өмнө эд хариуцагчдын хариуцаж байгаа бараа материалын үнэ бүхий зүйл, мөнгөн касс, агуулахыг лацлам ломбодох болон харуул хамгаалалтын талаар илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авахыг холбогдох хүмүүст шаардах;

3/ тооллогын явц дундуур түүхийг эд, бараа материал, мөнгөн хөрөнгийг хүлээн авах, тавьж олгох явдлыг бүрэн зогсоох, хариу байгууллагын хэвийн ажиллагааг тасалдуулахгүйн тулд тооллогын

комиссын хяналтын дор зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгцээний айлшгүй шаардлагатай түүхий эд, материалыг гаргах ба хүлээн авахыг зөвшөөрөх.

73 дугаар зүйл. Эд хөрөнгийн тооллого явуулах журам

1. Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн аймаг үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн оорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно:

1/ эд хөрөнгийн хэвийн хорогдлын нормоос хэтрээгүй дутагдлыг Үйлдвэртэл, үйлчилгээний зардалд бичнэ;

2/ нэг эд хариуцагчийн хариуцлагад байсан нэг нэр төрлийн дил үнэтэй бараа материалын үнэт зүйлийн илүү дутууг хооронд нь арьцуулж хааж болно;

3/ нэр төрлийн материал үнэ бүхий зүйлийн дутагдлыг бусад үнэ үхий зүйлийн илүүдлээр нэг эд хариуцагчаас гарсан дутагдлыг өгөө эд хариуцагч дээр гарсан илүүдлээр, хоёр өөр хугацаанд ирсэн нэг төрлийн адил үнэтэй зүйлийн дутагдлыг илүүдлээр хаа-ыг хориглоно. Харин тооллогоор илэрсэн илүүдлийг зохих дансанд рлого болгож илүүдэл гарсан шалтгааныг тогтооно;

4/ үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн утагал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн ундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар дэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад илжүүлнэ.

2. Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа мате-гал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан үрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн зтор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган алгана.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Орон нутгийн өмчийн зүйлс

74 дүгээр зүйл. Орон нутгийн өмчийн зүйлсийн тухай ойлголт

1. Орон нутгийн өмчийн зүйлс нь энэ хуулийн 3 дугаар зүйлд асны дагуу нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн гчөөс бүрдэнэ.

2. Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид тухайн орон тгийн хүн амын нийтийн хэрэгцээнд зориулсан эд хөрөнгө маарна.

75 дугаар зүйл. Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах  
Орон нутгийн өмчид эд хөрөнгийг дараахь хэлбэрээр олж авна:  
1/ энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1-4 дэх хэсэгт заасан хэлбэрээр  
бий болсон эд хөрөнгө;

2/ төрийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилж шил-  
жүүлсэн эд хөрөнгө;

3/ орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон  
нутгийн өмчид ногдох ашгаар олж авсан эд хөрөнгө;

4/ хуульд заасан бусад үндэслэлээр бий болсон эд хөрөнгө.

76 дугаар зүйл. Орон нутгийн өмчийг өмчлөх эрх  
дуусгавар болох

Орон нутгийн өмчийг өмчлөх эрх Иргэний хууль, бусад хуульд  
заасан үндэслэлээр дуусгавар болно.

77 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл  
сум, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь  
байна.

2. Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах захиран зарцуулах  
талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй:

1/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн халгалалт, хамгаалалтыг  
байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион  
байгуулах;

2/ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаан  
орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зар-  
цуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан  
нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;

3/ орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хуваачлах ба бусад  
шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг  
хэлэлцэж батлах. Хуваачлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг  
батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө;

4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн  
байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт  
тавих.

3. Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын  
өмчлөлд шилжүүлэх, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын  
Тэргүүлэгчид шийдвэртэнэ.

4. Хурлын Тэргүүлэгчид нь тухайн хурлын хуралдааны чөлөө  
цагт энэ хуулийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэг  
жүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд харигуцан тайлагнахаа  
гална орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн

итгээд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг  
илгүүнэ.

5. Нутгийн удирдах байгууллагад орон нутгийн өмчийн асуудал  
заруусан ажилтан буюу ажлын алба уг ажлыг эрхэлнэ.

78 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи Засаг даргын  
бүрэн эрх

1. Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн  
өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын  
юстицод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

2. Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүнэ:

1/ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний  
отор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах захиран зарцуулах;

2/ орон нутгийн өмчиг хуулийн этгээдийн эрх баригчийг  
эмилэх;

3/ орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилж, өөрчлөх саналыг  
Гурлын Тэргүүлэгчдэд оруулах;

4/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөглөх,  
д хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;

5/ орон нутгийн өмчиг албан байгууллагыг шаардлагатай эд  
өрөнгөөр хангах;

6/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийг Төрийн өмчийн хөрсөн  
эргэмэл, арга зүйн удирдлагын дор хувьчлах ажлыг зохион  
байгуулах;

7/ нутгийн өмч эрхэлсэн ажилтан буюу албыг шуурхай удирдах.

79 дүгээр зүйл. Орон нутгийн өмчиг хуулийн этгээдийн  
эд хөрөнгийн эрх

Орон нутгийн өмчиг хуулийн этгээд нь энэ хуулийн 14,16,17,21  
үгээр зүйлд заасан эрх эдэлнэ.

80 дугаар зүйл. Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах,  
захиран зарцуулах журам

Орон нутгийн өмчийг эзэмших, захиран зарцуулахтай холбогдсон  
ирилшээг энэ хуулийн тавдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна.

81 дүгээр зүйл. Орон нутгийн өмчийг хувьчлах

1. Орон нутгийн өмчийг хувьчлах ажлыг энэ хуулийн зургадугаар  
бүлэгт заасан арга хэлбэр, журмаар явуулна.

2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шаардлагатай гэж үзвэл Тө-  
рийн өмчийн хөрсөнд захиалгаа өгч хувьчлах ажлыг хийлгэж болно.

## ЕСЛҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

82 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлтгэх хариуцлага  
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд эрүүгийн хариуцлага хүлээлтгэхгүйгээр бол Төрийн өмчийн хорооны эрх бүхий албан тушаалтан зөрчлийн шинж байдлыг харгалзан дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/ төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөв шөөрөлгүйгээр хамдмалсан, бэлэглэсэн, барьцаалсан, зээлдүүлсэн бусад өмчийн хуулийн этгээлд хувь хөрөнгө болгон оруулсан бол гэм буруутай албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгож учирсан хохирлыг нөхөн төлүүлэх,

2/ энэ хуульд заасан журмыг зөрчиж төрийн өмчийн эд хөрөнгийг худалдсан, түрээслүүлсэн бол гэм буруутай этгээдийг 25000-60000 төгрөгөөр торгож, уг хохирлыг нөхөн төлүүлэх.

83 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийн зургадугаар бүлгийг 1996 оны 6 дугаар сарын 15-н өдрөөс, бусад бүлгийг 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ОЙ, ХЭЭРИЙГ ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ТУХАЙ

### НЭГЛҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ой, хээрийг түймрээс сэргийлэх түймэртэй тэмцэх, унтраах, учирсан хохирлыг арилгахтай холбогдож үүсэх хариуцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль тогтоомж

Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль тогтоомж нь энэ ууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад хтаас бүрдэнэ.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ

**Ой, хээрийг түймрээс хамгаалах талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг**

3 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар ой, хээрийг түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх алаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ ой, хээрийг түймрээс хамгаалах талаар төрийн бодлогыг эрэгжүүлэх;

2/ түймэртэй тэмцэхэд шаардагдах техник хэрэгсэл болон бусад үйлдлийн нормативыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний ниллогтой уялдуулан тогтоож мөрдүүлэх;

3/ түймрийн үед хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, нуулах журмыг батлах;

4/ ой, хээрийн түймрийг унтраах ажилд оролцож буй иргэдийн ингамж, тэдгээрийн заавал эзэмшсэн байх зүйлийн жагсаалтыг тглах;

5/ түймрийн улмаас байгаль орчинд учирсан хохирлыг арилгах, кологийн тэнцлийг хангах зорилгоор газар, ой, ургамал, амьтны илгийг ашиглах хэмжээг хязгарлах, зогсоох;

6/ хуульд заасан бусад бүрэн эрх.

4 дүгээр зүйл. Төрийн байгууллагуудын бүрэн эрх

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв ийгууллага ой, хээрийг түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх алаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль тогтоомжийн телэлтийг зохион байгуулах;

2/ түймрээс сэргийлэх зорилгоор тухайн бүс нутагт байгаль уингтой харьцах тодорхой үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох;

3/ онцгой болон хамгаалалтын бүсийн ойг цэвэрлэх, арчлах, ороон болон халз зурвас гаргах зэрэг түймрээс хамгаалах арга мжээний улсын захиалга өгч мэргэжлийн байгууллагуудаар йцэтгүүлэх;

4/ түймрээс учирсан хохирлын хэмжээг тогтоолгох, байгаль орч- аг нөхөн сэргээх талаар улсын захиалга өгч судалгаа, шинжил-

ний ажил гүйцэтгүүдэх, үр дүнг тооцож, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

5/ түймрийн аюултай үед хариуцсан нутаг дэвсгэртээ хамгаалалтын дэглэмдээ нийцүүлэн тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох эрхийг улсын тусгай хамгаалалттай газрын захиргаанд олгох;

6/ цаг агаарын болон түймрийн цагийн байдлын тухай мэдээллээр холбогдох байгууллага, хүн амыг хангах;

7/ хуульд заасан бусад бүрэн эрх.

2. Иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ой, хээрийг түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

1/ энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3-т заасан журмын дагуу дайчилгаа явуулж, түймрийг унтраах арга хэмжээ авах;

2/ иргэдийг түймрээс сэргийлэх, түймэртэй тэмцэх, унтраах арга ажиллагаанд сургах, нэгдсэн сургалт зохион байгуулах.

3 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн  
иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ ой, хээрийг түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх төлөвлөгөө, төсөв баталж, биелэлтэд хяналт тавина.

6 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны  
Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэлийн Засаг дарга ой, хээрийг түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

1/ түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шаардгдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгах, багаж хэрэгсэл, хүнс, бусад зүйлийн байнгын нөөцийг Засгийн газраа тогтоосон нормативын дагуу бий болгон сэлгэж байх;

2/ иргэдийг түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх, амь бие, эл хөрөнгөө хамгаалах арга ажиллагаанд сургаж дадлагажуулах ажил зохион байгуулах;

3/ хилийн цэргийн анги, салбартай хамтран улсын хилийн дагуу зураасыг бий болгох, тэдгээрийг байнга сэргээх, цурав татах, ойн цэвэрлэгээ хийх;

4/ түймэр гарсан үед бүрэн эрхийнхээ хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан түймэр унтраах ажлыг шуурхай зохион байгуулах;

5/ түймрийн хохирлыг тогтоох, арилгах арга хэмжээ авах, энэ зорилгоор ажлын хэсэг байгуулж ажиллуулах.

2. Сум, дүүргийн Засаг дарга ой, хээрийг түймрээс хамгаалах,

түймэртэй тэмцэх талаар энэ зүйлийн I дэх хэсгийн 1,2,4,5-д зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгах;

2/ төмөр зам, хот хоорондын зам, иргэдийн өвөлжөө, хаваржаанд түймрийн хамгаалалтын зурвас хийлгэж, хүлээн авах;

3/ нутаг дэвсгэртээ түймрийн аюултай үед эргүүл, харуул ажиллуулах;

4/ түймэртэй тэмцэхэд дайчлах хүн хүч, тээврийн хэрэгслийн тоо хэмжээ, дайчилгааны дэс дараалал, хуваарийг түймрийн аюултай үеэс өмнө жил бүр гаргаж мөрдүүлэх;

5/ ой, хээр аялах, жуучлах, зугаалах, ан агнах, бугын эвэр түүх, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах болон бусад үйлдвэртэл, үйлчилгээ эрхлэхэд байнгын хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд дээрх үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох.

3. Баг, хорооны Засаг дарга ой, хээрийг түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ түймрээс хамгаалах сурталчилгааг хүн бүрт хүргэж түймэртэй тэмцэх бэлтгэлийг хангуулах;

2/ түймэртэй тэмцэх ажлыг нэн даруй зохион байгуулах, хүн хүч, техник хэрэгслийг дайчлах, түймэр гарсан тухай болон түймрийг унтраах ажлын явцыг дээд шатны Засаг дарга болон холбогдох бусад байгууллагад шуурхай мэдээлэх;

3/ нутаг дэвсгэрээ айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад хуваарилан хариуцуулж хяналт тавиулах;

4/ түймрийн шалтгаан, гаргасан этгээд, хохирлыг тогтооход эрх бүхий байгууллагад дэмжлэг үзүүлэх.

7 дугаар зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

1. Иргэн түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

1/ түймрийн аюултай үед түлсэн гал, асаасан шүдэнэ, татсан тамхины гал, цог, нурмыг бүрэн унтраах;

2/ гэр, байшин, бэлтгэсэн өвс, худаг, малын хашаа, саравчны эргэн тойронд хамгаалалтын зурвас хийх;

3/ айл өрх бүр үнс, нурмыг тусгайлан бэлдсэн таглаа бүхий нүх, саванд хийж, түймэр алдахгүй байх нөхцөлийг хангах;

4/ түймрээс амь бие, эд хөрөнгөө хамгаалах, түймэртэй тэмцэх ирга ажиллагааг эзэмшсэн байх, үр хүүхдээ түймрээс сэрэмжлүүлж зургах;

5/ түймрийн аюултай үед эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийг эй, хээрт шүдэнэ, асаагуур болон бусад гал үүсгэгчтэй явуулахгүй байх;

6/ айл өрх бүр түймэр унтраах багаж хэрэгсэлтэй байх;

7/ гарсан түймрийг унтраах ажиллагаанд иргэний журамт үүргийн дагуу оролцох, түймэр илрүүлсэн, түймрийн тухай мэдээ хүлээн авсан бол түүнийг унтраах арга хэмжээ авч Засаг дарга, бусад холбогдох байгууллагад яаралтай мэдээлэх.

2. Аж ахуйн нэгж, байгууллага түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

1/ түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэхэд хүн хүч, тээврийн болон бусад хэрэгслийг гаргаж өгөх;

2/ ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг биелүүлэх ажлыг үйл ажиллагааныхаа хүрээнд зохион байгуулах;

3/ ой, хээрт мод бэлтгэх, эрэл, хайгуул, судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэхдээ хууль тогтоомжид заасны дагуу зөвшөөрөл авсан байх, түймрийн аюултай үед дээрх болон аялал, зугаалга зэрэг үйл ажиллагаа явуулахдаа сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авч, түймэр гаргахгүй байх баталгаа өгөх;

4/ галын аюултай бодис, шатах, тослох материалыг хэрэглэх, тээвэрлэх, хадгалах журам, горимыг чанд мөрдөх;

5/ бүх төрлийн тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох, ажилд гаргахдаа шалгаж байх;

6/ түймрийн тухай мэдээ авсан, илрүүлсэн тохиолдолд өөрийн хүч хэрэгслэлээр түймэр унтраах арга хэмжээ авч, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд шуурхай мэдээлэх.

## ГУРАВДУГААР БҮДЭГ

### Бусад зүйл.

8 дугаар зүйл. Түймрийн шалтгаан, гаргасан этгээд, учирсан хохирлыг тогтоох

1. Ой, хээрийн түймэр гарсан шалтгаан, буруутай этгээдийг тогтоох ажлыг цагдаагийн байгууллага хэрэгжүүлнэ.

2. Түймрээс учирсан хохирлыг зохих шатны Засаг даргын ажлын хэсэг түймэр унтарснаас хойш 30 хоногт багтаан тогтооно.

3. Ой, хээрийн түймрийн хор уршигт экологийн болон эд материалын хохирол, түймэртэй тэмцэхэд гарсан шууд болон шууд бус зардлыг оруулан тооцно.

4. Түймрийн хохирлыг тооцох журмыг Засгийн газар тогтооно.

9 дүгээр зүйл. Түймрийн мэдээ, тайлан

1. Бүх шатны Засаг дарга түймрийн цагийн байдлын тухай мэдээг дээд шатны Засаг дарга болон байгаль орчны асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өдөр тутам шуурхай мэдээлнэ.

2. Түймрийн талаархи мэдээ, тайланг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хагас, бүтэн жилээр гаргаж иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өгнө.

10 дугаар зүйл. Ой, хээрийн түймэртэй тэмцэх дайчилгааг зохион байгуулах

1. Бүх шатны Засаг дарга хүн хүч, техник хэрэгслийг дайчлан нутаг дэвсгэртээ гарсан түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулах бөгөөд түүнтэй холбогдсон Засаг даргын шаардлагыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заавал биелүүлэх үүрэгтэй.

2. Түймэртэй тэмцэх дайчилгаанд 16 нас хүрээгүй хүн, 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй хүн, тахир дутуу болон архаг өвчтэй хүн, жирэмсэн эмэгтэй, асрамжлах хүнгүй, сургуулийн өмнөх насны хүүхэдтэй хүн, байнгын тасралтгүй ажилдаагаатай /эмнэлэг, холбоо зэрэг/ газрын ээлжийн ажилтан самрагдахгүй.

3. Улсын хил, аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэр дамжсан орон нутгийн хүчээр унтраах боломжгүй түймэртэй тэмцэхэд цэргийн албан хаагч, цагдаагийн байгууллагын ажилтныг эрэлцүүлэх асуудлыг Засгийн газар шийдвэртэнэ.

4. Түймэртэй тэмцэх ажилд дайчлагдсан иргэдийг хоол хүнс, зусад хангамж, тээврийн хэрэгсэл, багаж, шатахуунаар хангах асуудлыг дайчилгаа зохион байгуулж буй төрийн байгууллага, албан ушаалтан хариушна.

11 дүгээр зүйл. Түймэр унтраах ажилд дайчлагдсан иргэн, төрийн албан хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа

1. Түймэр унтраах ажилд дайчлагдсан иргэн, төрийн албан хаагч түймэртэй тэмцэх иргэний журамт болон албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон, амь наснаа алдсан тохиолдолд түүнд буюу ар гэрт нь дараахь тэтгэвэр, тэтгэмж, цалингийн зөрүү, ардлыг олгоно:

1/ хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, авч байсан цалингийн зөрүү;

2/ тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр, авч байсан цалингийн зөрүү;

3/ амь наснаа алдсан тохиолдолд ар гэрт нь тэжээгчээ алдсаны этгэвэр, хохирогчийн авч байсан цалингийн зөрүү;

4/ хиймэл эрхтэн хийлгэх бол түүний зардал.

2. Ой, хээрийн түймэртэй тэмцэж яваад амь наснаа алдсан иргэн, өрийн албан хаагчийн оршуулгын зардлыг төр хариушна.

3. Ой, хээрийн түймэрт дайчлагдсан иргэн, төрийн албан хаагч түймэртэй тэмцэж яваад амь насаа алдсан тохиолдолд түүний аргарт нь нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлж болно. Тусламжийн хэмжээг Засгийн газар тогтооно.

12 дугаар зүйл. Санхүүжилт

1. Түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, нийслэл сум, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.

2. Ой, хээрийн түймрийн хор уршгийг арилгах зардлыг улсын төсвөөс гаргаж, түймэр гарсан шалтгааныг тогтоосны дараа түүнийг гэм буруутай этгээдээр зохих хууль тогтоомжийн дагуу нөхөлтөлүүлнэ.

3. Түймрийн хор уршиг, хөнөөл ихэссэн үед энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3-г заасан журмын дагуу дайчилгаа явуулахад гарсан зардлыг Засгийн газраас санхүүжүүлж болно.

13 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд зөрчлийн шинж байдал, хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2. Шүүгч, иргэний хамгаалалтын хяналтын улсын байцаагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан түймрээс хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/ энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2,3,7; 2 дахь хэсгийн 1-6-д заасан үүрэг, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг биелүүлээгүй иргэнийг 1000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000-250000 төгрөгөөр торгох;

2/түймрийг унтраах, учирсан хохирлыг арилгахад төрөөс олгосон хөрөнгийг өөр зориулалтаар ашигласан албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000-250000 төгрөгөөр торгох.

3. Ой, хээрийг түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэхтэй холбогдсон үүргээ биелүүлээгүй Засаг даргад Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын хариуцлага ногдуулна.

14 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг баталсан өдрөөс дагаж мөрднө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 8 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

### "ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ"-Д ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Эрчим хүчний тухай Монгол Улсын хууль"-ийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 8 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 8 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3,4,5,6,9,10 дахь хэсгийн дараахь заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дахь хэсгийн "8 дугаар сарын 10-ны" гэснийг "7 дугаар сарын 10-ны";

2/4 дэх хэсгийн "9 дүгээр сарын 1-ний" гэснийг "8 дугаар сарын 1-ний";

3/5 дахь хэсгийн "9 дүгээр сарын 20-ны" гэснийг "8 дугаар сарын 20-ны";

4/6 дахь хэсгийн "9 дүгээр сарын 20-ны" гэснийг "8 дугаар сарын 20-ны";

5/9 дэх хэсгийн "10 дугаар сарын 20-ны" гэснийг "9 дүгээр сарын 20-ны";

6/10 дахь хэсгийн "11 дүгээр сарын 1-ний" гэснийг "10 дугаар сарын 1-ний".

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 9 дүгээр  
сарын 3-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Төв Банк /Монголбанк/-ны тухай хууль", "Банкны тухай хууль" батлагдсантай холбогдуулан 1991 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн "Банкны тухай хууль", 1992 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн "Банкны хуульд өөрчлөлт оруулах тухай" хууль, 1993 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн "Банкны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль", 1994 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Банкны хуульд өөрчлөлт оруулах тухай хууль", 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн "Банкны хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг 1996 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их  
Хурлын дэд дарга

Ц. ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 9 дугаар  
сарын 3-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАНКНЫ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь банк байгуулах болон банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түүнийг хүчингүй болгох, банкны удирдалаг, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банкнийг өөрчлөн байгуулах, онцгой дэглэм тасгаар, банкны эрх хүлээн авах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Банкны тухай хууль тогтоомж

1.Банкны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Төв Банк /Монголбанк/-ны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд банкны тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

1.Бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах /цаашид "мөнгөн хадгаламж" гэх/, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох /цаашид "зээл" гэх/, талбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх /цаашид "талбөр тооцоо" гэх/ үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн төлөө хуулийн этгээдийг банк гэнэ.

2.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томёог дор дурасан утгаар ойлгоно:

1/ "холбогдох этгээд" гэж тухайн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, бусад ажилтан, дүрмийн сангийн тодорхой хувь болон хувьцаа эзэмшигч,тэдгээртэй төрөл садан /эцэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн ах, эгч, дүү, үр хүүхэд, гэдний гэр бүлийн хүн/-гийн холбоотой этгээдийг хэлнэ;

2/"удирдлага" гэж банкны гишүүдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл,гүйцэтгэх захирлыг хэлнэ;

3/"тодорхой хувь болон хувьцаа эзэмшигч" гэж банкны дүрмийн сангийн тав буюу түүнээс дээш хувийг шууд ба шууд бусаар эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

4 дүгээр зүйл.Банкны төрөл

Банк нь дүрмийн сангийн өмчлөлөөр төрийн, хувийн болон холимог, үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат, банкны үйл ажиллагаа явуулах хэлбэрээр нийтлэг ба төрөлжсөн байж болно.

5 дугаар зүйл.Банкны үйл ажиллагаанд үл нөлөөлөх

1.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Монголбанк,төрийн захиргааны бүх шатны байгууллага банкны үйл ажиллагаанд эрэлцэхгүй бөгөөд удирдлага,шийдвэрт нь хууль бусаар нөлөөлж болохгүй.

2.Банк төрийн хүлээх үүргийг хариуцахгүй,өөртөө тухайлан үүлээгээгүйгээс бусад тохиолдолд банкны хүлээх үүргийг төр ариуцахгүй.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Банкны үйл ажиллагаа

6 дугаар зүйл.Банкны эрхлэх үйл ажиллагаа

1. Банк Монголбанкны зөвшөөрөлтэйгээр мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаа болон дараахь ажил, үйлчилгээг эрхэлж болно:

1/ өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд төлбөрийн баталгаа гаргах;

2/ гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;

3/ үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;

4/ үнэт зүйл хадгалах;

5/ гадаад төлбөр тооцоо хийх;

6/ үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;

7/ санхүүгийн гүрээсийн гүйлгээ хийх;

8/ хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх;

9/ хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ.

2. Банкны бус, байгууллага Монголбанкны зөвшөөрөлгүйгээр мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаа болон энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2,3,5-д заасан ажил, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

7 дугаар зүйл. Банкнд хориглох үйл ажиллагаа

1. Банк ашиг олох зорилгоор банкны бус үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно. Зээлийн барьцаалсан эд хөрөнгийг, зээл төлүүтэх зорилгоор түр эзэмших, худалдаж борлуулах үйл ажиллагаа энэ заалтад хамаарахгүй.

2. Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд задлах ашиглахыг банкны гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтанд хориглоно:

1/ тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

2/ Монголбанк шаардсан;

3/ хуульд заасан бусад тохиолдол.

3. Банкаас олгосон зээлийн талаархи банк хоорондын мэдээлэл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нууцал хамаарахгүй.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна банк дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

1/ дангаараа буюу бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр ноёрхох, өөр хоорондоо, эсхүл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, ийм үйл ажиллагаанд оролцох;

2/ газрын зах зээлд ажиллах;

3/өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зэр сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх.

8 дугаар зүйл. Мөнгөн хадгаламж

1.Банк Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдгээрийн хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр хадгалж, түүнд хүү төлж болно.

2.Банкинд мөнгөн хөрөнгө хадгалах болон хадгаламжийн даатгала даатгуулахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

9 дүгээр зүйл. Зээл

1.Банк иргэн,хуулийн этгээдэд өөрийн болзол,нөхцлийн дагуу зээл олгож болно. Банк зээлийн хүүг өөрөө тогтооно.

2.Банк хугацаандаа төлөгдөөгүй зээл, хүүгийн төлбөрт зээлдэгчийн өмчлөлд байгаа эд хөрөнгө, хувьцаа дүрмийн сангийн-ногдол хувийг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр авч болох бөгөөд энэ нь нэ хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасанд хамаарахгүй.

3.Банкны зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

10 дугаар зүйл. Төлбөр тооцооны үйлчилгээ

1.Банк өөрийн харилцагчид төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээг түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлнэ.

2.Банк харилцагчийн даалгавараар түүний харилцах дансны үлдэгдэлд багтаан мөнгөн хөрөнгийг шилжүүлэх гүйлгээ хийнэ. Шүүх болон банкны эрх хүлээн авагчийн шийдвэртэй, эсхүл үл аргагдах журмаар төлөх тухай харилцагчийн гарын үсэг бүхий эрээ, төлбөрийн баримтыг үндэслэн гүйлгээ хийснийг харилцагчийн даалгавараар гүйлгээ хийсэнд тооцно.

3.Төлбөр тооцооны үйлчилгээний хөлсийг банк өөрөө тогтооно.

4.Банк нь банк хоорондын гүйлгээгээ Монголбанк дахь харилцах дансларал дамжуулан хийнэ.

5.Банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

11 дүгээр зүйл. Төлбөрийн баталгаа гаргах

Банк энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1-ээс 3 дахь хэсэгт заасан язгаарлалтын хүрээнд гуравдагч этгээдэд гэрээний дагуу төлбөрийн баталгаа гаргаж болно.

12 дугаар зүйл. Үнэт зүйлийн хадгалалт

Банк иргэний үнэт зүйлийг /хадгалуулагчийн хувьд үнэт зүйл/ адгалах үйлчилгээг эрхлэхдээ хадгалалтын гэрээний нөхцлийг хууль ортоомжинд нийцүүлэн өөрөө тогтооно.

13 дугаар зүйл. Гадаад валютын төлбөр тооцоо

Гадаад төлбөр тооцооны болон гадаад валют, түүгээр илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэгслийг худалдан авах, худалдахтай холбогдсон банкны үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл. Үнэт цаас гаргах, худалдан авах, худалдах

1. Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хязгаарын дотор хувицаа, түүнтэй адилтгах хэлбэрийн үнэт цаасыг барьцаанд авах, худалдах, худалдан авах талаархи банкны үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.

2. Банк мөнгөний зах зээл дээр арилжаалагдах нэг жил хүртлээ хугацаатай үнэт цаасыг Монголбанкны зөвшөөрлөөр гаргах буюу худалдан авч, худалдаж болно.

15 дугаар зүйл. Банкнд тавих шаардлага

1. Банк дараахь шаардлагыг хангаж ажиллана:

1/заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу зохих хэмжээ, хэлбэрээр хангахын зэрэгцээ хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх;

2/өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцаанж шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу биелүүлэх;

3/харилцагч хэд хэдэн банкаар үйлчлүүлэхэд хязгаарлалт тавихгүй байх;

4/харилцагчийн зөвшөөрөлгүйгээр харилцах данснаас нэ зарлагын гүйлгээ хийхгүй байх;

5/тухайн банкнаас үзүүлэх үйлчилгээний урьдчилсан нөхцөл болгож өөрийн салбар, төлөөлөгчийн газраар үйлчлүүлэхийг харилцагчид шаардахгүй байх.

2. Банк өөрийн үйл ажиллагааны тухай мэдээллийг Монгол-банкнаас тогтоосон бүртгэлийн зарчим, жишгийн дагуу харилцагч этгээдэд үнэн зөвөөр гаргаж өгнө.

16 дугаар зүйл. Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт

1. Банкнаас нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгох зээл, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй.

2. Банкнаас гаргах төлбөрийн баталгааны нийт дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.

3. Тухайн банкны гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, бусад ажилтан болон тэдгээрт холбогдох этгээдэд олгох зээл, төлбөрийн баталгааны дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтэрч болохгүй бөгөөд ийнхүү олгоходоо дараахь шаардлагыг баримтална:

1/ зээл олгоход тавих шаардлага, зээлийн хүү, нөхцөл нь тухайн

банкны зээл олгох ердийн шаардлага, хүү нөхцлөөс хөнгөлөлттэй байж болохгүй;

2/банкны дүрмийн санд оруулсан хөрөнгийг нь барьцаалан зээл олгохгүй байх;

3/олгосон зээлийн төлөгдөх хугацаа нь 6-аас дээш сараар хэтэрсэн бол тухайн этгээд банкны удирдах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохыг хориглох.

4/Банкны худалдан авах буюу барьцаа болгож авах хувьцаа, түүнтэй адилтгах хувьцаа хэлбэрийн үнэт цаасны эзэмшлийн нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэргч болохгүй бөгөөд энэ нь нэг компаний гаргасан хувьцааны нийт дүнгийн 5 хувиас дээшгүй байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Банк байгуулах

17 дугаар зүйл. Банк үүсгэн байгуулах

1.Төсвөөс санхүүждэг хуулийн этгээд, шашны болон олон нийтийн байгууллага, энэрэнгүй үйлсийн сангаас бусад хуулийн этгээд, иргэн банк үүсгэн байгуулж болно.

2.Банк байгуулах зөвшөөрлийг гагцхүү Монголбанк олгоно.

3.Гадаад оронд банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулахад Монголбанкны зөвшөөрөл авна.

18 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг

1.Банк үүсгэн байгуулагч дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

1/банк үүсгэн байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;

2/банк үүсгэн байгуулах гэрээ;

3/банкны дүрэм;

4/банк байгуулах эдийн засгийн үндэстэл;

5/үүсгэн байгуулагч болон тухайн банкны дүрмийн сангийн 10 буюу түүнээс дээш хувийг эзэмших этгээдийн нэр, хаяг, хувь чийлүүлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны сүүлийн 2 жилийн өндлөнгийн хяналтын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

6/Монголбанкнаас баталсан маягтын дагуу бүрдүүлж өгсөн банкны удирдлага, боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, ажлын зайрны талаархи тодорхойлолт.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бүрдүүлж өгсөн баримт бичгийг дутуу буюу тодорхой бус гэж үзвэл Монголбанк эдгээр баримт бичгийн хүрээнд нэмэлт материал шаардах эрхтэй.

Шаардлагатай гэж үзвэл Монголбанк үүсгэн байгуулагч, хувьчлүүлэгч, банкны удирдлагатай холбоотой асуудлаар шүүх, хууль

хяналтын байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авч болно.  
19 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгоход тавих нэмэлт шаардлага

Гадаадын хөрөнгө оруулалттай банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл авахад энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүтж Монгол банкинд өгнө:

1/ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, банкны салбар, төлөөлөгчийн газраа байгуулах тухай гадаадын банк, санхүүгийн байгууллагын гаргасан шийдэр;

2/ банк, санхүүгийн байгууллагыг тухайн орондоо бүртгэгдсэн болохыг нотлох баримт, хөндлөнгийн хяналтын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;

3/ хууль тогтоомжид заасан бусад баримт бичиг.

20 дугаар зүйл. Банк байгуулах зөвшөөрөл олгох

1. Банк байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл, бусад баримт бичгийг Монголбанк хянахдаа дараахь шаардлага хангагдсан эсэхийг тогтооно:

1/ банкны үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай явуулахад хүрэлцэхүйц хэмжээний дүрмийн сангаас бүрдсэн өөрийн хөрөнгөтэй эсэх;

2/ банкны гүйцэтгэх захирал болон удирдах бусад ажилтан нь банкны үйл ажиллагааг шударга, үр ашигтай явуулах хангалттай мэдлэг, туршлага, банкны ашиг сонирхлыг хувийн эрх ашгаан эрхэмд үзэх ёс суртахууны төлөвшилтэй эсэх;

3/ тухайн банк байгуулснаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эсэх.

2 Банк байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг Монгол банк энэ хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан баримт бичгийг бүрдэлийг хянасны эцэст хүлээн авна. Хэрэв нэмэлт материал шаардлагатай бол уг нэмэлт материалыг бүрдүүтж өгсөн өдрийн өргөдөл хүлээн авсан өдөрт тооцно.

3 Монголбанк банк байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэр гаргаж, энэ тухай үүсгэн байгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

4 Монголбанк энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг банк байгуулах зөвшөөрөл өгснөөс хойш 1 сарын дотор дүрмийн сангийн доод хэмжээг төлсөн нөхцөлд тогтоосон журмын дагуу тухайн банкинд олгоно.

21 дүгээр зүйл. Зөвшөөрөл олгохоос татгалзах

Монголбанк дараахь нөхцөлд банк байгуулах зөвшөөрөл олгохгүй:

1/энэ хуулийн 17, 18, 19, 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй ;

2/банкны дүрэм нь хууль тогтоомжтой зөрчиддсөн ;

3/байгуулах банк нь шаардлага хангахуйц хэмжээний дүрмийн санг бүрдүүлэх боломжгүй нь тогтоогдсон болон бүрдүүлсэн баримт бичиг нь хуурамч тухайн банкны удирдлагад ажиллах хүмүүс гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон .

22 дугаар зүйл. Банкнийг бүртгэх

1.Энэ хуулийн 17, 18, 19, 20 дугаар зүйлд заасан журмын дагуу Монголбанкны зөвшөөрөл авсан банк улсын бүртгэлд бүртгүүлдэг.

2 Банкны салбар, төлөөлөгчийн газрыг байгуулахад Монгол-банкнаас зөвшөөрөл авах бөгөөд түүнийг тусгайлан бүртгэхгүйгээр толгойлох банкных нь зөвшөөрөлд тэмдэглэнэ.

3.Банкийг улсын бүртгэлд бүртгэсэн тухай нийтэд мэдэгдэнэ.

23 дугаар зүйл. Банкны нэр

1.Банкны нэр нь түүний оноосон нэр болон "банк" гэсэн үгнээс бүрдэнэ.

2.Банкны бус байгууллага "банк" гэсэн нэр хэрэглэхийг хориглоно.

3.Банкны нэр байршлыг Монголбанкны зөвшөөрөлтэйгээр өөрчилнө.

4.Банкны салбар нь толгойлох банкны оноосон нэрийг хэрэглэнэ.

24 дүгээр зүйл. Банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгох

1.Монголбанк банк байгуулах зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгож нийтэд зарлана:

1/банк дампуурсан тухай эрх бүхий байгууллага зарласан;

2/банк байгуулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь банкнийг бүртгэснээс хойш нэг жилийн дотор илэрсэн;

3/банк үүсгэн байгуулагч дүрмийн сангаа тогтоосон хугацааны дотор бүрэн бүрдүүлээгүй ;

4/банкнийг улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш нэг жилээс дээш хугацаанд банкны үйл ажиллагаа явуулж эхлээгүй;

5/өөрчлөн байгуулах буюу татан буулгах замаар үйл ажиллагаагаа зогсоох тухай банкны гишүүдийн хурлын шийдвэр гарсан.

2.Банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгосноор банкны үйл ажиллагаа эрхлэх талаар урьд олгосон бүх зөвшөөрөл хүчингүй болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Банкны удирдлага, зохион байгуулалт

25 дугаар зүйл. Банкны удирдлага

1. Банкны эрх барих байгууллага нь гишүүдийн хурал байна.

2. Банкны гишүүдийн хурал дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

1/Банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/дүрмийн сангийн бүтэц, хэмжээг өөрчлөх;

3/банкнийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон асуудлыг шийдвэртэх;

4/хөндлөнгийн хяналтын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, балансыг хэлэлцэж батлах;

5/төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг сонгох, цөлөөлөх, түүний эрх хэмжээ, хариуцлага, ажлын хөлс, урамшууллын хэмжээг тогтоох, тайланг хэлэлцэх;

6/банкны хянан шалтгагч /хянан шалтгагчдын зөвлөл/-ийг эрх бүхий байгууллагаас нийтэд зарласан мэргэшсэн нягтлан бодогчдын нэрсийн жагсаалтаас сонгож, тэдгээрт олгох ажлын хөлс урамшууллын хэмжээг тогтоох тайланг хэлэлцэх.

3. Банкны төлөөлөн удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/банкны хэтийн чиглэл болон тухайн оны бизнес төлөвлөгөөг батлах;

2/банкны удирдлага, зохион байгуулалтын бүтэц, захиргааны зардлын хэмжээг тогтоох;

3/зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сангаас бусад сан байгуулж, зарцуулах журмыг тогтоох;

4/банкны гүйцэтгэх захиралтай хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулж, түүнийг томилж, үйл ажиллагаанд нь хяналт тавих, өөрчлөх;

5/банкны өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээ, хариуцлагыг тогтоох;

6/гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар гишүүдийн хуралд санал, дүгнэлт гаргах.

4. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг банкны дүрмээр зохицуулна.

5. Банкны гишүүдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулах журамтай холбогдсон харилцааг Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 43, 44, 47 дугаар зүйлээр зохицуулна.

6. Банкны гүйцэтгэх захирал дуудь тогтоомж, Банкны дүрэм

болон хөлсөөр ажиллах гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулна.

7. Банкны гүйцэтгэх захирал дарамь шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөнө:

1/ банк, банкны харилцагчийн эрх ашгийг хувийн эрх ашгаасаа илүүд тавьж, мэргэжил, ажлын дадалга, туршлагаа дайчлах;

2/ үүрэг гүйцэтгэх явцад олж авсан банк, банкны харилцагчийн талаархи мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

3/ өөрт нь болон өөртэй нь холбогдох этгээдэд тухайн банктай бизнесийн харилцаанд орсон этгээдийн санхүүгийн үр дүнг сонирхох шалтгаан байгаа бол ашиг сонирхлын зөрчил байна гэж үзэж, энэ тухайгаа төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр мэдэгдэх;

4/ хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх

26 дугаар зүйл. Банкны дүрэм

1. Банкны дүрэмд дор дурдсан зүйлтийг заавал тусгана:

1/ банкны оноосон нэр, оршин байгаа газар, хаяг;

2/ эрхлэх ажил, үйлчилгээний хүрээ;

3/ дүрмийн сангийн хэмжээ;

4/ банкны удирдлага, зохион байгуулалтын бүтэц;

5/ гишүүдийн хурал хуралдах болон төлөөлөн удирдах зөвлөлөөс үйл ажиллагаа явуулах журам;

6/ дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам;

7/ банк, банкны ажилтны нэр хүндийг хамгаалах, аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон асуудал.

2. Банкны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр Монголбанкинд мэдэгдэж, бүртгүүлнэ.

27 дугаар зүйл. Банкны өөрийн хөрөнгө

1. Банк өөрийн хөрөнгөтэй байна. Банкны өөрийн хөрөнгө нь дүрмийн сан болон бусад сангаас бүрдэнэ.

2. Дүрмийн сан банкны гишүүдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ 400 сая төгрөг байна.

3. Банкны бус салбарт хөрөнгө оруулсан гадаадын хөрөнгө оруулагч өөрт ногдох ашгаас салбарт хөрөнгө оруулж болно.

4. Банк нь банк байгуулах зөвшөөрөл авснаас хойш 6 сарын дотор зарлагдсан дүрмийн сангаа бүрэн бүрээшлэнэ.

5. Банк дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх тухай шийдвэрээ Монголбанкинд тухай бүр мэдэгдэнэ.

6. Банк өөрийн хөрөнгийн хэмжээг ашиг, алдагдлаараа буюу эзэл гөлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг илүү, дутуу байгуулсан хэсгээрээ нэмэгдүүлж, эсхүл хорогдуулж тодорхойлно.

7. Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан байгуулах, зарцуулах журмыг Монголбанк Сангийн яамтай хамтран тогтооно.

8. Энэ зүйлийн 7 дахь хэсэгт зааснаас бусад санг байгуулах журмыг банк өөрөө тогтооно.

9. Банкны гишүүн дүрмийн санд оруулсан хөрөнгөө Монгол банкны зөвшөөрлөөр бусдад худалдахаас өөрөөр буцааж авахыг хориглоно. Дүрмийн санд оруулсан хөрөнгийг худалдсанаас гишүүдийн бүтцэд орсон өөрчлөлт нь тухайн банкинд тавих хяналт, шалгалтанд саад учруулахаар бол Монголбанк зохих зөвшөөрлийг олгохгүй байх эрхтэй.

10. Банкны гишүүн дүрмийн санд оруулсан өөрийн хөрөнгө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүтээнэ.

28 дугаар зүйл. Санхүүгийн тайлан

1. Банкны санхүүгийн тайлан нь баланс, орлого, зарлагын болон холбогдох бусад тайлан, нэмэлт тайлбар, тодруулгаас бүрдэнэ. Банкны санхүүгийн тайлангай холбогдсон нэмэлт нотлох баримтыг Монголбанк шаардах эрхтэй.

2. Банк санхүүгийн тайлангаа Монголбанкнаас тогтоосон бүртгэлийн зарчим, жишгийн дагуу гаргах бөгөөд түүнийг Монгол банкнаас зөвшөөрөл авсан хөндлөнгийн хяналтын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа баталгаажуулж байна.

3. Банк баталгаажуулсан санхүүгийн тайлангийн хураангуйг нийтэд мэдээлэх бөгөөд түүний үзүүлэлтийн хэлбэрийг Монголбанк, Сангийн яам хамтран тогтооно.

29 дүгээр зүйл. Татвар төлөх

1. Банк зохих хууль тогтоомжийн дагуу татвар төлнө.

2. Банкны зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгийг татвар ноглох орлогоос хасч тооцно.

30 дугаар зүйл. Банкны гишүүдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгах үндсэн нөхцөл

1. Банкны гишүүдийн хурлын шийдвэр, монголбанкны зөвшөөрлөөр өөрчлөн байгуулж, татан буулгаж болно.

2. Банкны өөрчлөн байгуулах, татан буулгах тухай зөвшөөрөл авахад дор дусан баримт бичгийг Монголбанкинд гаргаж өгнө.

1/ банкны өөрчлөн байгуулах, татан буулгах тухай гишүүдийн хурлын шийдвэр;

2/ банкны өөрчлөн байгуулах, татан буулгах шаардлага, хэлбэр, нөхцөл, хугацааг заасан баримт бичиг, тухайн банкнаас үйл ажиллагаагаа дуусгавар болгохтой холбогдуулан авах арга хэмжээ, тэдгээрийн хугацаа, үе шат, гишүүдийн хурлаар хэлэлцэж, хөндлөнгийн

хяналтын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон шаардлагатай бусад мэдээлэл;

3/ банкнийг өөрчлөн байгуулснаас гарах санхүүгийн үр дүнгийн тооцоо, өөрчлөн байгуулсны дараа байгуулагдах банкны эхлэлтийн тайлан тэнцэл.

3. Монголбанк банкыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэж нийтэд мэдээлнэ. Монголбанк холбогдох баримт бичгийг хүлээн авсан өдрийг тооцохдоо энэ хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтална.

4. Банкнийг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай гишүүдийн хурлын шийдвэр хууль тогтоомж зөрчсөн, харилцагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол Монголбанк зөвшөөрөл өгөхөөс татгалзана.

5. Банкнийг татан буулгах тухай Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн хууль тогтоомжид заасан журмын дагуу банкнийг татан буулгана.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Банкинд хүлээлгэх албадлагын арга хэмжээ

31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчсөн банкны талаар авах албадлагын арга хэмжээ

Банк хууль тогтоомж болон Монголбанкны бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан шийдвэрийг зөрчсөн бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан Монголбанк албадлагын дараахь арга хэмжээг авна:

- 1/ албан бичгээр сануулга өгөх;
- 2/ зөрчлийг арилгах талаар хугацаа тогтоосон даалгавар өгөх;
- 3/ банкны үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах, зогсоох;
- 4/ торгууль ногдуулах;
- 5/ банкны гүйцэтгэх захирлыг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, нөлөөлөх, цалин хөлс, нөхөн олговор авахыг нь зогсоох;
- 6/ онцгой дэглэм тогтоох;
- 7/ банкны эрх хүлээн авах;
- 8/ банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгох.

32 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээ авах ерөнхий зарчим

1. Монголбанк энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу албадлагын арга хэмжээ авахдаа адил зөрчилд адил арга хэмжээ авах зарчмыг баримтална.

2. Албадлагын арга хэмжээ авах тухай Монголбанкны шийдвэр

рийг үндэслэлгүй гэж үзвэл холбогдогч этгээд шүүхэд гомдол гаргаж болно.

3. Албадлагын арга хэмжээ ногдуулсан нь бусад хууль тогтоомжийн дагуу хүлээлгэх хариуцлагас банкныг чөлөөлөх үндэслэл болохгүй.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Банкинд онцгой дэглэм тогтоох

33 дугаар зүйл. Онцгой дэглэм тогтоох

1. Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-т заасан шаардлагыг 3 сарын хугацаанд хангаагүйгээс төлбөрийн чадваргүй болж болзошгүй нь Монголбанкны хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөлд Монголбанкны шийдвэрээр тухайн банкны хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн байдлыг нь сайжруулах зорилгоор удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн болон холбогдох бусад арга хэмжээг цогцолбороор нь авч хэрэгжүүлэхийг банкинд онцгой дэглэм тогтоох гэнэ.

2. Онцгой дэглэм тогтоосон банкинд Монголбанк тухайн банкыг удирдах бүрэн эрхт төлөөлөгч буюу бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөл /шаашид "бүрэн эрхт төлөөлөгч" гэх/-ийг нэг жил хүртэл хугацаагаар томилно. Бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журмыг энэ хуульд нийцүүлэн Монголбанк тогтооно.

3. Онцгой дэглэм тогтоож хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны зардлыг тухайн банк хариуцна.

4. Тухайн банкны гишүүн онцгой дэглэм тогтоох тухай Монголбанкны шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй Гомдол гаргасан нь онцгой дэглэм тогтоох шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

34 дүгээр зүйл. Онцгой дэглэм тогтоох шийдвэр

1. Монголбанк онцгой дэглэм тогтоох тухай шийдвэрт дараахт зүйлийг тусгана:

- 1/ банкны нэр, оршин байгаа газар, хаяг;
- 2/ онцгой дэглэм тогтоох болсон үндэслэл;
- 3/ онцгой дэглэм хэрэгжүүлж эхлэх болон түүний үргэлжлэх хугацаа;
- 4/ банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтын жагсаалт;
- 5/ бүрэн эрхт төлөөлөгчийн овог, нэр.

2. Монголбанк онцгой дэглэм тогтоосон тухай шийдвэрээ нийтэд мэдээлнэ.

35 дугаар зүйл. Бүрэн эрхт төлөөлөгч томилох

1. Онцгой дэглэм тогтоосон банкныг удирдах бүрэн эрхт төлөөлөгчөөр Монголбанк өөрийн ажилтныг, эсхүл бусад этгээдийг томилж болно.

2. Бүрэн эрхт төлөөлөгчийн цалин хөлсийг Монголбанк тогтооно.

3. Бүрэн эрхт төлөөлөгч үйл ажиллагаандаа хууль тогтоомж болон энэ хуультай нийцүүлэн гаргасан Монголбанкны журам, дирдамжийг баримтална.

4. Монголбанк бүрэн эрхт төлөөлөгчийг өөрчлөх эрхтэй.

5. Бүрэн эрхт төлөөлөгч өөрийн буруутай үйл ажиллагааны дмаас учруулсан хохирлыг хариуцна. Банкны үйл ажиллагааны эрдийн эрсдэлд хамруулж болох хохирол учирсан нь бүрэн эрхт төлөөлөгчид хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

36 дугаар зүйл. Онцгой дэглэмийн үед авах арга хэмжээ, бүрэн эрхт төлөөлөгчийн эрх, үүрэг

1. Монголбанк онцгой дэглэм тогтоохдоо дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1/ банкны гишүүний эрхийг түдгэлзүүлэх;

2/ тухайн банкны төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, албар, нэгжийн удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх;

3/ тухайн банкыг удирдах эрх мэдлийг бүрэн эрхт төлөөлөгчид үр шилжүүлэх.

2. Бүрэн эрхт төлөөлөгч дараахь эрх, үүрэгтэй:

1/ тухайн банкны бүх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар бие даан шийдвэр гаргах;

2/ шаардлагатай гэж үзвэл онцгой дэглэм тогтоосон хутагтаанд усдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбогдох үүргийг бүрмөсөн, схүл хэсэгчлэн биелүүлэхийг түдгэлзүүлэн зогсоох;

3/ тухайн банкнаас урьд нь харилцагчтай хийсэн зээл, хадгалам-гийн болон бусад гэрээний нөхцөл нь банкны тухайн үеийн рөнхий нөхцлөөс өөрөөр тогтоогдож, банкны эрх ашигт сөргөөр өлөөлсөн гэж үзвэл уг гэрээнд өөрчлөлт оруулах;

4/ банкны нэрийн өмнөөс гэрээ байгуулах;

5/ банкны нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах;

6/ банкнаас ажиллагсадтай байгуулсан хэдэлмөрийн гэрээг ушлах, түүнд өөрчлөлт оруулах, шаардлагатай ажилтныг түр хуга-дагаар авч ажиллуулах.

3. Бүрэн эрхт төлөөлөгчийн шийдвэрийг тухайн банк, түүний албар нэгж биелүүлэх үүрэгтэй. Энэхүү шийдвэрийг дагаж мөрд-өнөөс үүсэх хариуцлагыг Монголбанк хүлээнэ.

4. Онцгой дэглэм тогтоогдсон банкны гүйцэтгэх захирал ажлын

тайлан, орлогын мэдүүдгээ зохих журмын дагуу бүрэн эрхт төлөөлөгчид гаргаж өгнө.

5. Бүрэн эрхт төлөөлөгчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр тухайн банкны нэрийн өмнөөс болон тухайн банкны зардалаар хийсэн ажил, гүйлгээг хүчингүйд тооцно.

6. Банкны хэвийн үйл ажиллагаа хангагдсан нөхцөлд Монгол банк онцгой дэглэмийг цуцалж, тухайн банкинд тогтоосон хязгаарлалтыг бүрмөсөн, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгоно. Онцгой дэглэм тогтоосон үед тухайн банкны дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт хүчинтэй хэвээр үлдэнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Банкны эрх хүлээн авах

37 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авах

Монголбанк банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгож банк, түүний удирдлагын бүрэн эрх болон банкны өөрийн хөрөнгийг өмчлөх эрхийг банкны эрх хүлээн авагчид шилжүүлэн банкний албадан татан буулгах үйл ажиллагааг банкны эрх хүлээн авах гэнэ.

38 дугаар зүйл. Банкнийг татан буулгах

1. Монголбанк дор дурдсан үндэслэлээр банкнийг татан буулгана:

1/ онцгой дэглэм тогтоосноор банкны хэвийн үйл ажиллагаа хангагдаагүй;

2/ банк хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгийг гарган өгч чадахгүй болсон;

3/ Монголбанкнаас тогтоосон журмаар тооцоход банкны пассив нь актив хөрөнгөөсөө хэтэрсэн;

4/ энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3-т заасан үндэслэл Монгол банкны тодорхойлсноор бий болох нь зайлшгүй болсон.

2. Монголбанк энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр банкнийг татан буулгах тухай шийдвэр гаргаж, тухайн банкны эрх хүлээн авагчийг томилно.

39 дүгээр зүйл. Банкны эрх хүлээн авагч

1. Монголбанк дараахь шаардлагыг хангасан өөрийн ажилтан буюу бусад этгээдийг банкны эрх хүлээн авагчаар томилно:

1/ банкны үйл ажиллагааны зохих мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвартай;

2/ эрүүгийн ял шийтгэлгүй буюу өмч хөрөнгөтэй холбогдсон асуудлаар иргэний хэрэгт хариуцагчаар татагдаж байгаагүй;

3/ тухайн банкнаас урьд нь авсан зээлийн өргүй;

4/ тухайн банкны гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

гишүүн, гүйцэтгэх захирал, бусад ажилтантай холбогдох этгээдийн харилцаагүй;

5/ банкны эрх хүлээн авагч нь хуулийн этгээд бол өөрийн үйл ажиллагааг хариуцах хангалттай хэмжээний хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй байх.

2. Банкны эрх хүлээн авагч нь Монголбанкны өмнө хариуцлага хүлээх бөгөөд шаардлага хангаагүй гэж үзвэл Монголбанк түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.

3. Банкны эрх хүлээн авагчийн цалин хөлсийг Монголбанк тогтоож, тухайн банкнаас гаргуулна.

4. Банкны эрх хүлээн авагч Монголбанкнаас гаргасан дүрэм, журам, тушаал, зааврыг дагаж мөрдөнө.

40 дүгээр зүйл. Банкны эрх хүлээн авагчийн бүрэн эрх хэрэгжих нөхцөл

1. Монголбанк банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгож, банкны эрх хүлээн авагчийг томилсноор:

1/ банк, түүний удирдлагын бүрэн эрх болон банкны өөрийн хөрөнгийг өмчлөх эрх нь банкны эрх хүлээн авагчид шилжинэ;

2/ тухайн банк бусад этгээдээс өмч, хөрөнгө, төлбөр хүлээн авах эрхийн хугацаа дуусаж байгаа буюу дуусах хугацаа нь 6 сараас доош хугацаагаар дөхсөн бол банкны эрх хүлээн авагчийг томилогдсоноос хойш уг эрхийг 6 сараар шууд сунгагдсанд тооцно.

2. Банкны эрх хүлээн авах үйл ажиллагаа хэрэгжих хугацаанд тухайн банкны актив хөрөнгийг борлуулснаас орох орлогоос үл маргах журмаар төлбөр гүйцэтгэхийг хориглоно.

3. Банкнаас хийгдсэн төлбөр, шилжүүлэг нь зарим этгээдийн эрх ашгийг бусдаас илүүтэйд үзсэн шинжтэй бол банкны эрхийг хүлээн авах үйл ажиллагаа эхлэхээс өмнөх 3 сарын дотор хийгдсэн төлбөрийг, хэрэв төлбөр хүлээн авагч нь банкны гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан, тэдгээрт холбогдох этгээд байвал банкны эрхийг хүлээн авах үйл ажиллагаа эхлэхээс өмнөх 12 сарын дотор хийгдсэн бүх төлбөрийг дор дурьдсанаар бусад тохиолдолд тус тус хүчингүйд тооцно:

1/ холбогдох хадгаламж эзэмшигчид төлсөн төлбөр нь тухайн үед нэг хадгаламж эзэмшигчид төлөхөөр Монголбанкнаас тогтоосон хязгаараас хэтрээгүй;

2/ бусдад шилжүүлсэн эд хөрөнгө нь уг эд хөрөнгийн зах зээлийн үнээр төлөгдсөн;

3/ банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтанд олгосон цалин хөлс нь тэдгээрт урьд нь олгож зайсан цалин хөлсний ердийн хэмжээнээс хэтрээгүй /шагнал, бусад гусгай нэмэгдэл үүнд хамаарахгүй/.

41 дүгээр зүйл. Банкны эрх хүлээн авагчийг томилсонтой холбогдуулан шүүхэд хандах

1. Банкны эрх хүлээн авагчийг томилсон нь үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлыг банкны эрх хүлээн авагчийг томилогдсоноос хойш 30 хоногийн дотор дараахь этгээд шүүхэд гаргах эрхтэй:

1/ банкны дүрмийн сангийн 25-аас доошгүй хувийг эзэмшсэн гишүүн;

2/ банкны нийт хадгаламжийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч;

3/ банкны төлөх бусад төлбөрийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүхэд гомдол гаргасан нь банкны эрх хүлээн авагчийн үйл ажиллагааг гүдгэлзүүлэх, зогсоох үндэслэл болохгүй.

3. Шүүх гомдлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

42 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авах ажиллагаа эхэлснийг зарлан мэдэгдэх

1. Банкны эрх хүлээн авагч томилогдсоноосоо хойш 24 цагийн дотор банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүчингүй болж удирдлага, хяналт нь түүнд шилжсэн тухай зарталыг тухайн банк, түүний салбарын байранд гаргаж, харилцагчид мэдэгдэнэ.

2. Банкны эрх хүлээн авагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зарталыг нийтэд мэдээлж, зарталын хувийг Монголбанкинд хүргүүлнэ.

43 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авагчийн бүрэн эрх

Банкны эрх хүлээн авагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ банкны тодорхой үйл ажиллагааг үргэлжлүүлэх, зогсоох;

2/ банкны төлөх төлбөрийг зогсоох, төлбөрийн хэмжээг хязгаарлах;

3/ хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг тухайн үеийн хадгаламжийн хүүгийн доод хувь хэмжээнээс багагүй байхаар өөрчлөн тогтоох;

4/ банкны хөрөнгө оруулалт хийхээр байгуулсан гэрээг цуцлах, зээлийн хүү, үйлчилгээний хөлсний хувь хэмжээ, хутацаанд өөрчлөлт оруулах;

5/ банкны байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээг цуцлах, шаардлагатай ажилтан авч ажиллуулах;

6/ шаардлагатай гэж үзсэн мэдээллийг нийтэд мэдээлэх;

7/ банкны нэрийн өмнөөс гэрээ байгуулах;

8/ банкны нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанад банкыг төлөөлж оролцох;

9/ бусдад олгосон зээлийн барьцаалсан эд хөрөнгийг үнэлж худалдан борлуулах;

10/ банкны нэрийн өмнөөс Монголбанкнаас тогтоосон хэмжээг баримтлан төлбөр хийх.

44 дүгээр зүйл. Банкныг татан буулгах урьдчилсан арга хэмжээ

1. Банкны эрх хүлээн авагч дараахь арга хэмжээг нэн даруй авч эрэгжүүлнэ:

1/ худалдаж борлуулах актив хөрөнгийн жагсаалт, бүртгэлийг аргаж, хуулбарыг нийтэд мэдээлэх;

2/ бусдын эзэмшилд байгаа банкны актив хөрөнгийг буцааж вах,

3/ хадгалалтын гэрээгээр авсан бусдын үнэт зүйлийг буцааж гөх;

4/ банкнаас авлагатай этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах угацааг тогтоож мэдэгдэх.

2. Банкны эрх хүлээн авагч энэ зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан этгээдийн ирүүлсэн нэхэмжлэлийг хангах хэлбэр, хэмжээ, элбөрийн хуваарь, дарааллыг тогтоож, нэхэмжлэлийг хүлээн авч авч хойш 2 сарын дотор холбогдох нэхэмжлэгчид мэдэгдэнэ.

45 дугаар зүйл. Төлбөр барагдуулах дараалал

1. Банкны эрх хүлээн авагч банкны активыг худалдаж эрлуулсан орлогоос нэхэмжлэгчийн шаардлагыг хангахдаа дараахь ираалтыг баримтална:

1/ бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлыг арилгуулах цаар шүүхээс шийдвэрлэснийг үндэслэн тухайн банкнаас гаргуулж ийсан төлбөр,

2/ банкны эрх хүлээн авах үйл ажиллагаатай холбогдож гарсан рдал;

3/ банкны эрх хүлээн авагч томилогдсоноос хойш бусдаас игосон зээлийн төлбөр;

4/ иргэний харилцах данс, хадгаламж, хүүгийн төлбөр;

5/ хуулийн этгээдийн харилцах данс, хадгаламж, хүүгийн төлбөр;

6/ бусдын олгосон зээлийн төлбөр;

7/ бусдад төлөх бусад өглөг.

2. Актив хөрөнгийг худалдаж борлуулснаас орох орлого нэхэмж-лийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол дарааллын эхний лбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн төлбөрийн ардлагыг хангах зэргийг баримтална.

3. Нэг дараалалд орсон хэд хэдэн төлбөрийг нэгэн зэрэг рагдуулж хүрэлцэхгүй тохиолдолд тус бүрийн төлбөрийн хэмжээнд нь тэнцүүлэн нэхэмжлэлийн шаардлагыг хангана.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлбөрийг бүрэн барагдуул-ы дараа үлдэх хөрөнгийг тухайн банкны гишүүдэд хувицааны руу ба ердийн эрх гэсэн дарааллаар хувь тэнцүүлэн хуваарилна.

46 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авагч банкны актив хөрөнгийг захиран зарцуулах

1. Банкны эрх хүлээн авагч банкны актив хөрөнгийг захиран зарцуулахтай холбогдсон дараахь үйл ажиллагааг томилогдсн өдрөөсөө хойш дор дурьдсан хугацаанд зохион байгуулна:

1/ гэрээний дагуу тухайн банкны өрийг түүнд ногдох акты хөрөнгийн хамт бүхэлд нь буюу хэсэгчлэн нэг жилд багтаан бусд банкинд шилжүүлэх;

2/ банкны актив хөрөнгийг 2 жилд багтаан худалдан борлуулах.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан үйл ажиллагаа хэрэгжүүлэхийн тулд банкны эрх хүлээн авагч нь:

1/ банкыг татан буулгасны дараа төлөх боломжтой хэмжээнд багагүйгээр тооцож банкны өр, хадгаламжийн төлбөрийг бууруулна

2/ банкны хадгаламж эзэмшигч, харилцагчид өгөх төлбөрө тухайн хадгаламж эзэмшигч, харилцагчаас авах зээлийн төлбөрийг суутгана.

3. Банкны эрх хүлээн авагч банкны актив хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагааг явуулахдаа хадгаламж эзэмшигчийн эрхийг бусдаас илүүд үзнэ.

47 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авах, татан буулгах ажиллагааг дуусгавар болгох

1. Банкны эрх хүлээн авагч банкны нийт актив хөрөнгийг худалдан борлуулж дууссан тухай тайлан гаргаж Монголбанкинд өгн. Энэхүү тайланг Монголбанк батлаж, нийтэд мэдэгдсэнээр банкны эрх хүлээн авах, татан буулгах ажиллагааг дуусгавар болсонд тооцн.

2. Банкны эрх хүлээн авах буюу татан буулгах ажиллагааг дуусгавар болсны эцэст төлөгдөөгүй үлдсэн тухайн банкны алир актив хөрөнгө нь Монголбанкны мэдэлд байна.

3. Банкны эрх хүлээн авахтай холбогдсон үйл ажиллагааг Монголбанкнаас санхүүжүүлэхийг хориглоно.

4. Банкнийг татан буулгасны эцэст төлөгдөөгүй зээлт холбогдолтой мэдээллийг зээлийн мэдээллийн санд хадгална.

48 дугаар зүйл. Бусад заалт

Банкны эрх хүлээн авах, банкнийг албадан татан буулгахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Хариуцлага

49 дүгээр зүйл. Монголбанкны хянан шалгагчааас хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Банкны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүт хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголба

ны хянан шалгагч дараахь хариуцлага ногдуулна:

1/ банк, банкны салбарыг зөвшөөрөлгүй нээсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж 200000-аас 250000 хүртэл төгрөгөөр торгох;

2/ банкны бус байгууллага Монголбанкны зөвшөөрөлгүйгээр банкны үйл ажиллагаа эрхэлсэн бол олсон орлогыг хурааж 150000-аас 200000 хүртэл төгрөгөөр торгох;

3/ банкны тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн гаргасан шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтныг 10000-аас 50000 хүртэл, банкнийг 50000-аас 200000 хүртэл төгрөгөөр торгох;

4/ хяналт шалгалтад саад учруулсан иргэнийг 5000-аас 20000 хүртэл, албан тушаалтныг 5000-аас 30000 хүртэл төгрөгөөр торгох;

5/ төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан буюу гүйлгээг саатуулсан албан тушаалтныг 10000-аас 50000 хүртэл, банкнийг 100000-аас 250000 хүртэл төгрөгөөр торгох;

6/ тайлан, тэнцэл, мэдээ баримтыг Монголбанкинд зохих журмын дагуу хугацаанд нь гаргаж өгөөгүй албан тушаалтныг 10000-аас 30000 хүртэл, банкнийг 50000-аас 200000 хүртэл төгрөгөөр торгох;

7/ энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй бол банкнийг 100000-аас 200000 хүртэл төгрөгөөр торгох.

2. Торгуулийн орлогыг улсын төсөвт оруулна.

3. Банкны тухай хууль тогтоомж зөрчсөнөөс учирсан эд сөрөнгийн хохирлыг Иргэний хуулийн дагуу нөхөн төлүүлнэ.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгуулийг үндэслэлгүй тогдуулсан гэж үзвэл захиргааны болон шүүхийн журмаар гомдол арга болно.

50 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж төрдөнө.

Монгол Улсын Их  
Хурлын дэд дарга

Ц. ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 9 дүгээр  
сарын 3-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Төв банк /Монголбанк/-ны бүрэн эрх, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн мөнгөний Төв Банк /Монголбанк/-наас хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төв Банк /Монголбанк/-ны тухай хууль тогтоомж

Төв Банк /Монголбанк/-ны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Төв Банк /Монголбанк/-ны эрх зүйн байдал

1. Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ. Монгол Улсын Төв Банкыг Монголбанк гэж нэрлэнэ. Монголбанкны төв нь Монгол Улсын нийслэлд байрлана.

2. Монголбанк нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд бөгөөд тогтоосон загвараар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Монголбанк өөрийн билэгдэл тэмдэгтэй байж болно.

4 дүгээр зүйл. Монголбанкны үндсэн зорилт

1. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

5 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагааны чиглэл

Монголбанк энэ хуульд заасан өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараахь чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ:

1/ мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах;

2/ эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

- 3/ Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;
- 4/ банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- 5/ банк хоорондын талбэр тооцоог зохион байгуулах;
- 6/ гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, зохицуулах.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Монгол Улсын мөнгөн тэмдэгт

6 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд  
гаргах онцгой эрх

1. Монголбанк Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрх эдэлнэ.

2. Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх, хуурамч мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргахыг хориглоно.

7 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгтийн нэгж, хэлбэр

1. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж нь төгрөг мөн. Нэг төгрөг зуун мөнгөтэй тэнцэнэ.

2. Монгол Улсын мөнгөн тэмдэгт нь цаасан дэвсгэрт болон зоосон хэлбэртэй байна. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн хэв загварыг Улсын Их Хурал батална.

8 дугаар зүйл. Талбөрийн хууль ёсны  
хэрэгсэл

1. Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төгрөг нь өөрийн гэртэсэн дүнгээрээ Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх талбэр тооцоонд хэрэглэгдэх талбөрийн хууль ёсны хэрэгсэл мөн.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол төгрөгийг орлох талбөрийн бусад гэрэгслийг Монголбанкны зөвшөөрлөөр талбэр тооцоонд хэрэглэж болно.

9 дүгээр зүйл. Мөнгөн тэмдэгттэй холбогдсон  
Монголбанкны үйл ажиллагаа

1. Монголбанк мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, гүйлгээнээс атах замаар гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн зохистой бүтцийг ангах үйл ажиллагаа явуулна.

2. Монголбанк мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, үүний нөөцийг бий болгох, хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлох, эмгэж муудсаныг солих, устгах ажлыг эрхлэн зохион байгуулна.

3. Гэмтэж муудсан мөнгөн тэмдэгт солих журмыг Монголбанк огтооно. Монголбанкны зөвшөөрөлгүйгээр мөнгөн тэмдэгт сгтахыг хориглоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Монголбанкны үйл ажиллагаа

10 дугаар зүйл. Мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх

1. Монголбанк төрийн мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.

2. Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн барих бөгөөд түүнд дараахь асуудлыг тусгасан байна:

1/ эдийн засаг дахь мөнгөний нийлүүдэлт, санхүүгийн зах зээлийн байдал, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тайлбарласан дүгнэлт;

2/ Монголбанкнаас дараагийн жилд баримтлах мөнгөний нийлүүдэлт, дотоодын үнэ болон харьцангуй тогтвортой гадаад валютын нэгжээр илэрхийлэгдэх төгрөгийн ханшийн үзүүлэлтийн өөрчлөлтийн хязгаар, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл.

11 дүгээр зүйл. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл

Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ дараахь хэрэгслийг ашиглаж болно:

1/ банкны заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг тогтоох;

2/ банкинд олгох зээлийн хэмжээг тогтоох;

3/ Монголбанкны зээл, үнэт цаасны хүү болон хямдруулалтын хувиар дамжуулж хүүгийн нэгдсэн бодлого явуулах;

4/ нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах;

5/ банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх.

12 дугаар зүйл. Банкны заавал байлгах нөөц

1. Монголбанк мөнгөний нийлүүдэлтийг зохицуулах зорилгоор иргэн, хуулийн этгээдийн банкин дахь харилцах данс, хадгаламжийн үлдэгдэл болон Монголбанкнаас тогтоосон банкны бусад пассивын дүнгийн тодорхой хувийг бэлэн нөөцийн байдлаар заавал байлгахыг банкнаас шаардана.

2. Монголбанк банкны заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нийт пассивын таван хувиар доошгүй, гучин хувиас дээшгүй байхаар тогтооно.

3. Банкны бэлэн нөөц нь тухайн банкны кассад байгаа бэлэн мөнгө ба Монголбанкны дахь харилцах дансны үлдэгдлийн хэлбэрээр байж болно.

4. Монголбанк банкны заавал байлгах нөөцийг хангасан хэсэг ногдох бэлэн нөөцөд хүү төлж болно.

5. Монголбанк заавал байлгах нөөцийг дутагдуулсан банкинд

торгууль ногдуулна. Торгуулийн дээд хязгаар нь тухайн үед Монгол-банкнаас банкинд олгох хамгийн өндөр хүүтэй зээлийн хүү дээр таван нэгж хувийг нэмсэнээс илүүгүй байна.

6. Банкны заавал байлгах нөөцийг тооцох, хяналт тавих журмыг Монголбанк тогтооно.

13 дугаар зүйл. Банкнд зээл олгох

1. Монголбанк эцсийн зээлдүүлэгчийн хувьд дараахь нөхцөлийг сангасан банкинд зээл олгож болно:

1/ зээл нь нэг жилийн дотор төлөгдөх Засгийн газрын өрийн бичиг, Монголбанкны үнэт цаас, Монголбанкнаас зөвшөөрсөн гарилцагчийн бичиж банкинд хямдруулж худалдсан вексель, Монголбанкнд дахь тухайн банкны харилцах данс, хадгаламж, Монголбанк хүлээн зөвшөөрөх бусад актив, үнэт цаасаар баталгаажсан;

2/ банкны төлбөрийн чадварт гурван сараас дээшгүй хугацааны үндрэл бий болсон, банк өөрийн үйл ажиллагааны үр дүнд уг үндрэлээс гарч, авсан зээлээ хугацаанд нь төлөх боломжтой гэж Монголбанк үзсэн.

2. Монголбанк мөнгөний нийлүүлэлтийн зорилтот үзүүлэлтийн агуу банкинд олгох зээлийн нийт хэмжээг тодорхойлсны үндсэн дээр нэг банкинд олгох зээлийн хэмжээг тухайн банкны зээлжих адварын хязгаарт багтаан тогтоох эрхтэй.

3. Монголбанк банкинд зээлийг хүүгээр өрсөлдүүлэх буюу үл өрсөлдүүлэх хэлбэрээр гэрээний үндсэн дээр олгож болно.

4. Банкнд зээл олгох нийтлэг журмыг энэ хуульд нийцүүлэн Монголбанк тогтооно.

14 дүгээр зүйл. Хүүгийн нэгдсэн бодлого явуулах

Монголбанк нь өөрийн зээл, үнэт цаасны хүү болон ямдруулалтын хувиар дамжуулан банкны хүүгийн нэгдсэн бодлого вуулна.

15 дугаар зүйл. Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах

Монголбанк банкны нөөцийг удирдах зорилгоор нэг жил хүртэлх гатаатай үнэт цаас гаргах, түүнийг худалдан авах, худалдах, засгийн газрын өрийн бичиг, Монголбанкнаас зөвшөөрсөн бусад этт цаасыг мөнгөний зах дээр худалдах, худалдаж авах замаар зээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй.

16 дугаар зүйл. Банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх

Монголбанк энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1-ээс 4-т заасан өнгөний нийлүүлэлтийг зохицуулах бодлогын хэрэгслийг хангалт-й гэж үзсэн тохиолдолд банкнаас иргэн, хуулийн этгээдэд олгох элийн үлдэгдэлд хязгаарлалт хийж болно.

17 дугаар зүйл. Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх

Монголбанк Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэхдээ дараахь үйл ажиллагааг явуулж болно:

1/ зохих нөхцлийг тусгасан гэрээний дагуу улсын төсвийн нэгдсэн дансыг Сангийн сайдын хүсэлтээр өөр дээрээ байршуулж, хол богдох гүйлгээг хийх;

2/ Засгийн газраас гаргасан өрийн бичгийг бусад этгээд зуучлан борлуулах ба төрийн мөнгөний бодлогын зорилт, зах зээлийн тухайн үеийн нөхцөл байдалд нийцэж байвал түүний худалдан авах, худалдах;

3/ Засгийн газрын болон түүнээс баталгаа гаргасан хуулийн этгээдийн гадаадаас авсан зээлийн төлбөрийн хуваарийг баримтла улсын төсвийн нэгдсэн дансны үлдэгдлийн хэмжээнд багтаа төлбөр тооцоо гүйцэтгэх;

4/ хууль тогтоомжид нийцсэн зуучлалын бусад үйл ажиллагаа эрхлэх.

18 дугаар зүйл. Засгийн газарт зээл олгох

1. Монголбанк төсвийн улирлын чанартай орлого, зарлагыг зөрүүг нөхөхөд зориулж тухайн санхүүгийн жил дуусахаас өмнө төлөгдсөн байх түр хугацааны зээлийг Засгийн газарт гэрээний үндсэн дээр олгож болно.

2. Тухайн санхүүгийн жилийн түр хугацааны зээлийн үлдэгдлийн нийт хэмжээ нь дотоодоос төсөвт сүүлийн гурван жилд орсо орлогын дунджийн арван хувиас хэтрэхгүй байна. Дотоодоос төсөв орох орлогод Засгийн газар өөрийн активыг зарж борлуулсан орлого болон дотоодын зээллэг, өрийн бичиг гаргаснаар олсо орлогыг хамааруулахгүй.

3. Засгийн газраас гаргасан өрийн бичгийг Монголбанк худалдаа авсан бол түүнийг Засгийн газарт олгосон зээлийн үлдэгдэл оруулж тооцно.

4. Засгийн газарт зээл олгох журмыг энэ хуульд нийцүүлэн Монголбанк тогтооно.

19 дүгээр зүйл. Банкны үйл ажиллагаанд хяналт тавих

1. Монголбанк хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл банкинд олгох, түүний өрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагаа нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

2. Банк байгуулах, банкны үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгох, хязгаарлалт хийх, шаардлаг

авих, хяналт шалгалт хийх, банкинд онцгой дэглэм тогтоох, банк-ы эрх хүлээн авах үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.

20 дугаар зүйл. Банк хоорондын төлбөр тооцоог  
зохион байгуулах

1. Монголбанк банк хоорондын төлбөр, харилцан суутгах тоо-оог зохион байгуулж болно. Банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкн дахь тухайн банкны харилцах дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

2. Монголбанк банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх өрийн салбар байгуулан ажиллуулж болно.

3. Банк хоорондын төлбөр тооцооны журмыг Монголбанк нгтооно.

21 дүгээр зүйл. Гадаад валютын улсын нөөцийг  
эзэмшиж, зохицуулах

1. Монголбанк эзэмшин, зохицуулж байгаа валютын улсын өөцийн гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай гйдлыг хангах үүрэгтэй. Зөвхөн эдгээр үүрэг бүрэн биелсэн эхцөлд гадаад валютын улсын нөөцийг ашиглан санхүүгийн зах ол дээр арилжаалагдах хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх замаар млогыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж болно.

2. Монголбанкн дахь гадаад валютын улсын нөөц дараахь өрлийн активаас бүрдэнэ:

1/ гадаад орны банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа нггөжсөн алт;

2/ бэлэн ба бэлэн бус хэлбэрээр байгаа чөлөөтэй хөрвөдөг гадаад лют;

3/ чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар чөлөөтэй төлөгдөх ксель;

4/ гадаад орны Засгийн газар, төв банк, олон улсын санхүүгийн йгууллагаас гаргасан буюу баталгаажуулсан чөлөөтэй хөрвөдөг гаад валютаар нэрлэсэн, түүгээр төлөгдөх бүх төрлийн өрийн чнг;

5/ олон улсын хэмжээнд гадаад валютын нөөцөд тооцогдох бусад гив.

3. Монголбанк гадаад валютын улсын нөөцийг зохицуулахдаа э зүйлийн 2 дахь хэсэгт заасан гадаад валютын нөөцийн рэлдэхүүн хэсгийг харилцан чөлөөтэй хөрвүүлэх, худалдах, алдан авах үйл ажиллагаа явуулж болно.

4. Монголбанк чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, түүнтэй адилтгах эгслийг төгрөгөөр худалдах, худалдаж авахдаа төгрөгийн твортой байдлыг хангана.

5. Гадаад валютын улсын нөөц нь Улсын Их Хурлаас тогтоосон

доод хэмжээнээс багссан, эсхүл валютын бодлогыг хэрэгжүүлэ болон улсын гадаад төлбөр тооцоог шуурхай явуулах болом алагдсаныг Монголбанк тодорхойлсон нөхцөлд Монголбанк Засгийн газартай хамтран холбогдох арга хэмжээ авна.

22 дугаар зүйл. Гадаад валютын зохицуулалт

1. Монголбанк гадаад валютын зохицуулалтыг хуульд заасн дагуу хэрэгжүүлнэ.

2. Монголбанк гадаад валюттай харьцах төгрөгийн ханшин бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ ханш нь чөлөөтэй бөгөө бодитой байх, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдий засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зарчмыг баримтална.

23 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагаанд хориглох зүйл

1. Монголбанкнаас дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ этгээдэд санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх;

2/ ашиг олох зорилгоор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө худалда авах, худалдах;

3/ Засгийн газар болон банкнаас бусад хуулийн этгээд, иргэни мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийг зээлийн үйл ажиллагаа эрхлэх;

4/ хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах, хувьцаа түүнтэй адилтгах хэлбэрийн үнэт цаас худалдан авах, худалдах.

2. Монголбанк үйл ажиллагаа явуулах нь энэ зүйлийн 1 дэ хэсэгт заасанд хамаарахгүй:

1/ авлага барагдуулах зорилгоор боломжтой хугацааны дото худалдах нөхцөлтэйгээр энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2,4-т зааса хөрөнгө, үнэт цаасыг худалдан авах;

2/ нийт дүнгээрээ өөрийн хөрөнгийн гурван хувиэ хэтрүүлэхгүйгээр дангаараа хадгаламжийн давтгал, экспорты санхүүжилт, төлбөр харилцан суутгах үйл ажиллагаа, автоматжуула банкны мэдээлэл боловсруулалт эрхэлдэг болон мөнгөний бодлогь хэрэгжүүлэхтэй шууд холбоотой хуулийн этгээдийн хувьцаа эзэмших;

3/ өөрийн ажилтанд хууль тогтоожийн дагуу санхүүгийн туслам үзүүлэх, зардалыг гаргах.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Монголбанкнаас банкинд тавих хяналт

24 дүгээр зүйл. Банкнд хяналт тавих Монголбанкны  
бүрэн эрх

1. Монголбанк энэ хуулийг хэрэгжүүлэх хүрээнд банкны үй ажиллагааг хянан шалгах эрхтэй.

2. Монголбанкны хяналт шалгалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн томилсон хянан шалгагч хэрэгжүүлнэ.

25 дугаар зүйл. Монголбанкны хянан шалгагчийн бүрэн эрх

1. Монголбанкны хянан шалгагч банкны хууль тогтоомж, төрийн төнгөний бодлого болон Монголбанкны гаргасан дүрэм, журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг банкнаас хэрхэн биегүүлж байгаад хяналт тавьж, шалгалт хийнэ. Хянан шалгагч нь лсын байцаагчийн эрх эдэлнэ.

2. Монголбанкны хянан шалгагч дараахь бүрэн эрхийг эрэгжүүлнэ:

1/ банкны байр, тасалгаа, бусад холбогдох газарт нэвтрэн орох;

2/ банкны данс бүртгэл, тайлан, тэнцэл, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулж авах, асуулт тавьж, ариулт авах;

3/ шаардлагатай магадлагаа, баримтын хуулбарыг уг банкны арилцагч аж ахуйн нэгж, банк, санхүүгийн болон бусад байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

4/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банкны үйл ажиллагааны холбогдох баримтыг шалгаж үзэх;

5/ банк, түүний үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг эрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу ихиргааны хариуцлага хүлээлгэх;

6/ хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

7/ Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны шалгуур үүлэлтийг хангаагүй буюу зээл төлөгдөхөд учирч болзошгүй цагдааас хамгаалах санг бүрэн байгуулаагүй банкны гишүүнд эгдэл ашиг хуваарилахыг зогсоох.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Монголбанкны удирдлага

26 дугаар зүйл. Монголбанкны удирдлага

1. Монголбанкийг Улсын Их Хурлаас томилогдсон Ерөнхийлөгч лгөйдж үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцан йлагдана. Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын ргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн гацаагаар томилно.

2. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч рыг Монголбанкны Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Улсын Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

3. Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилохдоо түүний эдийн засаг, банк, санхүү удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй ажлын туршлагыг харгалзана.

4. Монголбанкны Ерөнхийлөгчийн эзгүйд Тэргүүн дэд ерөнхийлөгч, Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд Ерөнхийлөгчийн эзгүйд Дэд ерөнхийлөгч тус тус орлон ажиллана.

5. Монголбанкны Ерөнхийлөгчийн цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

6. Улсын Их Хурал Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг дор дурдсан тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ:

- 1/ арилжааны банкны хувьцаа эзэмшигч болсон;
- 2/ Монголбанкны эрх ашигт харш үйлдэл /эс үйлдэл/ гаргасан;
- 3/ биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, у албан тушаалаас чөлөөлж өгөхийг хүссэн;
- 4/ үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;
- 5/ гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон;
- 6/ ашиг сонирхлын бусад зөрчил үүссэн.

7. Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нар үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш нэ жилийн дотор банкны удирдах албан тушаалд ажиллахыг хориглоно  
27 дугаар зүйл. Монголбанкны Зөвлөл

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн дэргэд Монголбанкны Зөвлөл ажиллана.

2. Зөвлөл нь Монголбанкны Ерөнхийлөгчийн бүрэн эрх, хамаарах асуудлаар зөвлөх эрхтэй.

3. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

28 дугаар зүйл. Монголбанкны ерөнхийлөгчийн бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх баталгаа

1. Монголбанкны Ерөнхийлөгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Монголбанк, түүний салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг зохицуулан удирдах;

2/ банкны үйл ажиллагааны зохистой харьцаа, хэм хэмжээ шаардлагыг тусгасан бодлого, санхүү бүртгэл, мэдээлэл, удирдлагыг зохион байгуулалт зэрэг асуудлаар дүрэм, журам, заавар тушаа гаргах;

3/ Улсын Их Хурлын Байнгын Хороо, Засгийн газар, холбогдо бусад байгууллагатай шууд харилцаж Улсын Их Хурлын чуулган,

байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд өөрийн байр суурийг гэрхийлэх;

4/ Монголбанкны өөрийн хөрөнгийн хэмжээнд багтаан түүний гэрийн өмнөөс Засгийн газар буюу банкинд төлбөрийн баталгаа арга;

5/ Монголбанкнаас үзүүлсэн ажил, үйлчилгээнд авах шимтгэл, лгосон зээлийн хүүгийн хувь, хэмжээг тогтоох;

6/ Монголбанкны зохион байгуулалт, бүтэц, орон тоо, жиллагсдын цалин хөлсийг тогтоох, ажилд томилох, ажлаас халах, рамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

7/ банкны гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөхөд түүний эргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар зэрэг асуудлаар банкны ишүүдтэй зөвшилцөх, шаардлагатай гэж үзвэл гүйцэтгэх захирлыг өрчлөх тухай банкны гишүүдэд зөвлөмж өгөх, банкны тухай хууль эгтөөмжид заасан үндэслэлээр гүдгэлзүүлэх, чөлөөлөх;

8/ төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай асуудлын талаар Засгийн газарт мэдээлэх, түүнтэй хамтарч шийдвэр гаргах;

9/ төрийн мөнгөний бодлогын хэрэгжилт, санхүүгийн зах зүйлийн байдлын талаар Монголбанкны дүгнэлт, саналыг Улсын Их урал, Засгийн газарт улирал тутам танилцуулах;

10/ банкны шийдвэр банкны тухай хууль тогтоомж, Монгол-инкны шийдвэртэй харшилж байвал түүнийг хүчингүй болгох;

11/ банкны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, эргэжлийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах;

12/ энэ хууль болон банкны тухай хууль тогтоомжийн төлөлтнийг аж ахуйн нэгж, байгууллагад шалган танилцаж, хуульд заасан арга хэмжээг авах, биелэлтийг нь бүрэн хангуулах талаар иалгавар өгч, гүйцэтгүүлэх;

13/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

2. Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ираахь баталгаагаар хангагдана:

1/ төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохирсон цалин нь шаардлагатай бусад хангамж эдлэх;

2/ уналга, холбооны хэрэгслээр хангагдах;

3/ гадаадад зорчих, байх хугацаанд дипломат эрх ямба, дархан их эдлэх;

4/ хуулиар тогтоосон бусад баталгаа.

3. Монголбанкны Ерөнхийлөгчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь юу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар ривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн тор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд Монголбанкны Ерөнхий-

лэгчийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр цагдан хорих, түүн шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, гэр орон, уналт албан тасалгаа, биед нь нэгжлэг хийхийг хориглоно.

4. Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд ул орон нутгийн албан дайчилгаандаас чөлөөлөгдөнө.

5. Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар хариуцуулсан үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаалыг хавсран эрхэлж болохгүй.

6. Монголбанкны Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд дуусгавар болоход түүнийг тодорхой ажил, албан тушаал эрхлүүлэх тийм боломжгүй бол чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд амьдралын түвшинг нь бууруулахгүй байх арга хэмжээг Улсын Их Хурал авна.

29 дүгээр зүйл. Монголбанкны албан тушаалтны үйл ажиллагаанд хориглох зүйл.

1. Монголбанкны албан тушаалтан дараахь үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно:

1/ аливаа аж ахуйн нэгж, байгууллагын ашиг сонирхлыг төлөөлөх;

2/ өөртөө болон гэр бүл, төрөл төрөгсөд, ажил төрлийн бусад бусад танил хүмүүст ашигтай давуу байдал бий болгох;

3/ банк, иргэн хуулийн этгээдийн дансны үлдэгдэл, түүн гүйлгээ, тэдгээрийн хоорондын гэрээ, хэлцэл, банкны үйл ажиллагааны талаархи албан баримтыг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад мэдээлэх, танилцуулах;

4/ хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.

2. Монголбанкны албан тушаалтан албан үүргийнхээ дагуу ол авсан мэдээ баримтын нууцыг хуульд зааснаас бусад тохиолдолд үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш 4 задруулж үл болно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Монголбанкиаас бусадтай харилцах

30 дугаар зүйл. Монголбанк Улсын Их Хуралтай харилцах

1. Монголбанк төрийн мөнгөний бодлого, хөлбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө, зээлийн байдлын талаар Улсын Их Хуралд улирал тутам танилцуулна.

2. Төрийн мөнгөний бодлогод тодорхойлсон үзүүтэлт Монголбанкны үйл ажиллагаанаас үл шалтгаалан эдийн засагт бий болсон нөхцөл байдлаас хамааран хэрэгжээгүй тохиолдолд эдгээр талаар Улсын Их Хуралд танилцуулна.

3. Монголбанк санхүүгийн тайлангаа жил бүр Улсын Их Хуралд танилцуулна.

4. Улсын Их Хурал Монголбанкны үйл ажиллагааг хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхэд хяналт тавих бөгөөд ингэхдээ өөрийн мөнгөний бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь оролцохгүй.

31 дүгээр зүйл. Монголбанкнаас Засгийн газартай харилцах

1. Монголбанкнаас Засгийн газартай харилцах үйл ажиллагаа нь нэ хуулийн 17, 18 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар зохицуулагдана.

2. Монголбанк Засгийн газраас хараат бус байна.

3. Засгийн газрын шийдвэр төрийн мөнгөний бодлогод харшилж яйвал Монголбанк энэ талаар Засгийн газарт мэдэгдэнэ.

4. Монголбанкны Ерөнхийлөгч Монголбанк болон банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлыг Засгийн газрын хуралданаар элэлцэхэд зөвлөх эрхтэй оролцож болно.

5. Монголбанк мөнгөний статистик мэдээлэл болон жилийн тайлангаа Засгийн газарт хүргүүлнэ.

32 дугаар зүйл. Монголбанкнаас банкттай харилцах

1. Монголбанк энэ хуулийн 12, 13, 16, 19, 20 дугаар зүйл болон банкны тухай хууль тогтоомжийн дагуу банкттай харилцана.

2. Монголбанк хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа банкны дотоод хэрэгт өндлөнгөөс оролцохгүй.

33 дугаар зүйл. Монголбанкны гадаад харилцаа

1. Монгол банк төрийн мөнгөний бодлого, банкны үйл ажиллагааны талаар олон улсын банк, гадаадын банк, санхүү, эхний байгууллагатай Монгол Улсын ашиг сонирхолд нийцүүлэн ууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу арилцаж ажиллана.

2. Монголбанк өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газар хоорондын хуралдаан, зөвлөлгөөнд Монгол Улсыг төлөөлөн оролцож болно.

3. Монголбанк зохих гэрээний дагуу гадаад улсын Засгийн газар, эв банк, Монгол Улс гишүүнээр нь элссэн олон улсын айлгууллагад банкны үйлчилгээ үзүүж болно.

4. Монголбанк олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, гадаадын банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

5. Монголбанк Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэхдээ Монгол Улс гишүүнээр нь элссэн олон улсын байгууллагатай хийх гүйцлгээг энэ хуулийн 17 дугаар зүйлийн 3-т заасны дагуу гүйцэтгэнэ.

34 дүгээр зүйл. Монголбанкны мэдээлэл

1. Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгслүүдэд гарсан өөрчлөлтийг тухай бүр нь, мөнгө, зээл, санхүүгийн зах зээлийн байдлыг улирал тутам нийтэд мэдээлж байна.

2. Монголбанк мөнгөний статистик мэдээллийг сар тутам гаргана.

3. Монголбанк энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан мэдээллийг гаргахад шаардагдах мэдээ, тайлан, үзүүлэлтийг банк, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авах эрхтэй.

4. Монголбанк хууль тогтоомжийн дагуу статистикийн мэдээлэл тайланг хэвтээд нийтлүүлдэг болно.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Монголбанкны өөрийн хөрөнгө, орлогын хуваарилалт

35 дугаар зүйл. Өөрийн хөрөнгө

1. Монголбанк үйл ажиллагаагаа явуулахад хүлээх үүргийн баталгаа болгох зорилгоор өөрийн хөрөнгөгтэй байна. Өөрийн хөрөнгө нь дүрмийн сан, ерөнхий нөөцийн сан, дахин үнэлгээний сан, бусад сан, цэвэр орлогоос бүрдэнэ.

2. Монголбанкны тайлан, тэнцлээр түүний активын бодит дүн нь пассив болон өөрийн хөрөнгийн нийлбэр дүнгээс багассан тохиолдолд тухайн тайлан, тэнцлийг албан ёсоор гаргаснаас хойш хоёр сарын дотор Засгийн газар уг зөрүүгийн хэмжээгээр зах зээлийн хүүтэй өөрийн бичиг гаргаж, Монголбанкинд байршуулах замаар Монголбанкны өөрийн хөрөнгийн дутууг нөхөх арга хэмжээ авна.

36 дугаар зүйл. Дүрмийн сан

1. Монголбанкны дүрмийн сан нэг тэрбум төгрөгөөс доошгүй байх бөгөөд энэ хэмжээг гагцхүү хуулиар өөрчилнө.

2. Монголбанкны дүрмийн сангийн хэмжээг энэ зүйлийн 1 дэх хэсэг болон Монголбанкны саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

37 дугаар зүйл. Монголбанкны цэвэр орлогыг тодорхойлох

1. Монголбанкны санхүүгийн жилийн цэвэр орлогыг тодорхойлоходоо дараахь зарчмыг баримтална:

1/ нийт орлого, зарлагыг зохих журмын дагуу хуримтлуулж тооцсон байх;

2/ чанаргүй зээл болон активын хорогдол, нийгмийн хөгжлийн арга хэмжээнд зориулан нөөцийн санг зохих журмын дагуу урьдчилан байгуулсан байх;

3/ зохих аргачлалын дагуу актив, пассивыг дахин үнэлсэн байх.

2. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан орлого, зарлагыг суримтлуулан тооцох, нөөцийн сан байгуулах, актив, пассивыг дахин үнэлэх журам, аргачлалыг Монголбанк тогтооно.

3. Актив, пассивыг дахин үнэлэх журмыг Монголбанк тогтооддоо гараах зарчмыг баримтална:

1/ гадаад валютын улсын нөөцөл тооцогдох актив болон үнэт металл, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр гарсан цэвэр зөрүүг дахин үнэлгээний холбогдох сангаар хлаа;

2/ тухайн санхүүгийн жилд дахин үнэлгээгээр гарсан цэвэр сдлагдлыг дахин үнэлгээний сан болон ерөнхий нөөцийн сангаар даж хүрэлцээгүй тохиолдолд зөрүүд нь тухайн санхүүгийн жил тууссанаас хойш дөрвөн сарын дотор Засгийн газраас зал зээлийн үүтэй өрийн бичиг гаргаж, Монголбанкинд байршуулах.

4. Актив, пассивыг дахин үнэлэхэд гарсан үнэлгээний цэвэр өрүү болон Монголбанкнаас гадаад валютын улсын нөөцийг шиглаж хийсэн хөрөнгө оруулалтын орлогыг Монголбанкны цэвэр рлогын тооцоонд хамааруулахгүй.

38 дугаар зүйл. Монголбанкны цэвэр орлогыг хуваарилах

1. Монголбанкны цэвэр орлогыг дор дурдсан дарааллаар уваарилна:

1/ дөчөөс доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд шимтгэх;

2/ энэ хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу айршуулсан Засгийн газрын өрийн бичгийг буцааж төлбөр хийх;

3/ энэ хэсгийн 1, 2-т заасан гүйлгээг хийсний дараа үлдэх эсгийг улсын төвлөрсөн төсөвт шилжүүлэх.

2. Монголбанк бүх төрлийн албан татвараас чөлөөлөгдөнө.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Монголбанкны бүртгэл, санхүүгийн тайлан

39 дүгээр зүйл. Монголбанкны санхүүгийн жил

Монголбанкны санхүүгийн жил нь хуанлийн жилтэй адил байна.

40 дүгээр зүйл. Монголбанкны санхүүгийн тайлан

1. Монголбанк нягтлан бодох бүртгэлийн жишгийн дагуу нхүүгийн тайлан гаргана.

2. Монголбанк жил бүр санхүүгийн тайлангад хөндлөнгийн иналтын байгууллагаар баталгаажуулан Улсын Их Хуралд интлуулна.

41 дүгээр зүйл. Санхүүгийн тайлангийн бүрдүүлбэр

Монголбанкны санхүүгийн тайлан нь тэнцэл, орлого, зарлагын тайлан, бусад холбогдох тайлан, нэмэлт тайлбар, тодруулгаан бүрдэнэ.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад заалт

42 дугаар зүйл. Хариуцлага

Төв банк /Монголбанк/-ны тухай хууль тогтоомж зөрчсөн нэрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны хянан шалгагч хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

43 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагах мөрдөнө.

Монгол Улсын Их  
Хурлын дэд дарга

Ц. ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 5 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар  
хот

### "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийг дагаж мөрдөх журмын тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль батлагдсантай  
салбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт  
шалгасугай:

1/ төрийн өмчийн талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа  
Засгийн газрын болон түүний байгууллагуудын шийдвэрийг энэ  
хуульд нийцүүлэх, түүнчлэн хуульд заасан журам, хэм хэмжээг 1996  
оны IY улиралд багтаан гаргах;

2/ төрийн өмчийн хорооны дүрэм, зохион байгуулалтын  
үтэц, орон тоог 1996 оны 7 дугаар сард батлан, хууль биелүүлэх  
элтгэл ажлыг хангуулах;

3/ хувьчилж үл болох төрийн өмчийн эд хөрөнгийн болон  
өрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн  
цагаалтын төслийг 1996 оны IY улиралд багтаан Улсын Их Хуралд  
ргөн мэдүүлэх;

4/ зохих удирдамжийг батлан гаргаж, бэлтгэл хангасны үндсэн  
ээр төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг 1997 оны I улиралд  
агтаан явуулж дүнг Улсын Их Хуралд танилцуулах;

5/ улсын үйлдвэрийн газруудын захирлыг энэ хуульд заасан  
өлзөл, журмын дагуу шалгаруулан томилж, гэрээ байгуулах ажлыг  
1997 оны 3 дугаар сард багтаан дуусгах;

6/ улсын үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэн баталж, 1997  
оны I дүгээр сарын I-ний дотор улсын бүртгэлд бүртгүүлэх;

7/ төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн  
өмчийн төлөөллийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай  
хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх ажлыг 1996 оны IY  
улиралд багтаан зохион байгуулах.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хүчин  
төгөлдөр болох хүртлэх хугацаанд хийсэн төрийн өмч хувьчлахтай  
салбогдсон харилцаа болон захиалгад орж бүртгэгдсэн хөрөнгө  
зуулалтын эрхийн бичгээр хийх хувьчлалыг Өмч хувьчлах тухай

хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актаг зохицуулж байсугай.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг зургадугаар бүлэгт заасны дагуу өмч хувьчлах ажлыг Төрийн өмчийг хороо байгуулагдах хүртэл хугацаанд Засгийн газрын өмч хувьчлах комисс эрхлэн гүйцэтгэж байхаар тогтоосугай.

ДАРГА

Н. БАГАБАНДИ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 5 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар  
хот

**Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай  
хуулийг хэрэгжүүлэх зарим арга  
хэмжээний тухай**

Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар даалгасугай:

1/ ой, хээрийг түймрээс хамгаалахтай холбогдсон тогтоол шийдвэрийг 1996 оны 9 дүгээр сарын 1-ний дотор багтаан Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуульд нийцүүлэх;

2/ Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуульд заасан журам жагсаалтыг 1996 оны 2 дугаар улиралд багтаан боловсруулж мөрдүүлэх;

3/ 1996 оны хавар гарсан түймэртэй тэмцэж яваад амь нас алдсан иргэн, төрийн албан хаагчид Ой, хээрийг түймрээс хамгаалж тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, цалингийн зөрүү, зардал тусламжийг олгох асуудлыг шийдвэрлэх.

ДАРГА

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

996 оны 8 дугаар  
арын 30-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар  
хот

**Судалгааны төвийг татан буулгах  
тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд заасныг үндэслэн Улсын Их урлын дэргэдэх Судалгааны төвийг татан буулгасугай.

2. Судалгааны төвийн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжийг Улсын Их Хурлын Тамгын газрын бүтээд ажиллуулахыг Тамгын газрын рөнхий нарийн бичгийн дарга /Л.Цог/-д даалгасугай.

3. Судалгааны төвийг татан буулгахтай холбогдуудан Улсын Их урлын 1994 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 15 дугаар тогтоог хүчингүй болсонд тооцсугай.

**ДАРГА**

**Р. ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

96 оны 8 дугаар  
арын 30-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Их Хурлын зарим  
Байнгын хороо, дэд хорооны  
бүрэлдэхүүний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13, 15<sup>1</sup> дүгээр зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**1/Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн  
байнгын хороо:**

1.Рагчаагийн Бадамдамдин

2.Шаравжамцын Батбаяр

3.Даржаагийн Батнасан

4. Намдагийн Батцэрэг
5. Эрдэнийн Бат-Үүл
6. Цэвэлмаагийн Баярсайхан
7. Надмидын Баяртсайхан
8. Данзангийн Бохьшарга
9. Цэрэндоржийн Ганхуяг
10. Жамбын Гомбожав
11. Сагдагийн Гончиг
12. Ендон-Ойдовын Гэрэлчулуун
13. Хэнмэдхэвийн Дашзэвэг
14. Жамбын Норовсамбуу
15. Жамъянгийн Отгонбаяр
16. Рэнцэнгийн Содхүү
17. Таукейн Султан
18. Санжбэгзийн Төмөр-Очир
19. Дониогийн Цогт-Очир
20. Цэрэнхүүгийн Шаравдорж

**2/ Нийгмийн бодлогын байнгын хороо:**

1. Ринчиниямын Амаржаргал
2. Нацагийн Багабанди
3. Шаравжамшын Батбаяр
4. Шийлэгийн Батбаяр
5. Даржаагийн Батнасан
6. Төгсжаргалын Ганди
7. Цэрэндоржийн Ганхуяг
8. Данзанхорлоогийн Даштүрэв
9. Пунцагийн Жасрай
10. Самбуугийн Ламбаа
11. Ринчингийн Нарангэрэл
12. Чүлтэмийн Отгонбаяр
13. Түвдэнгийн Очирхүү
14. Норжмаагийн Тогтох
15. Санжбэгзийн Төмөр-Очир
16. Цэвээндоржийн Төмөртогтоо
17. Чүлтэмийн Улаан
18. Долгорын Хувьтогддор
19. Хашбатын Хулан
20. Чимэдийн Сайханбилэг
21. Должингийн Цогбадрах
22. Данзанбалжирын Энхтайван

**3/Төрийн байгуулалтын байнгын хороо:**

1. Ендонпунцагийн Адилбиш

- 2.Нацагийн Багабанди
- 3.Бат-Эрдэнийн Батбаяр
- 4.Батжаргалын Батбаяр
- 5.Эрдэнийн Бат-Үүд
- 6.Намдагийн Батцэрэг
- 7.Сэрээтэрийн Болдхэт
- 8.Данзангийн Бохьшарга
- 9.Жамсрангийн Бямбадорж
- 10.Сангажавын Баярцогт
- 11.Ажланы Болат
- 12.Төгсжаргалын Ганди
- 13.Галсанпунцагийн Ганхуяг
- 14.Жамбын Гомбожав
- 15.Раднаасүмбэрэлийн Гончигдорж
- 16.Огирбатын Дашбалбар
- 17.Хэнмэдхэвийн Дашзэвэг
- 18.Данзанхорлоогийн Дашлүрэн
- 19.Пунцагийн Жасрай
- 20.Санжаасүрэнгийн Зориг
- 21.Мэндийн Энээ
- 22.Данзангийн Лүндээжанцан
- 23.Ринчингийн Нарангэрэл
- 24.Цэндийн Нямдорж
- 25.Рэнчинсамбуугийн Одонбаатар
- 26.Жамъянгийн Отгонбаяр
- 27.Раздакийн Сандалхан
- 28.Сорогжоогийн Төмөр
- 29.Мишигийн Чимэдшэрэн
- 30.Хашбатын Хулан
- 31.Нямаагийн Түвшинтөгс
- 32.Дамдинсүрэнгийн Энхбаатар
- 33.Ойдовын Энхтуяа
- 34.Цагаандарийн Энхтүвшин
- 35.Ямааранзын Эрхэмбаяр

**4/ Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын  
байнгын хороо:**

- 1.Норовын Алтанхуяг
- 2.Ринчингийн Амаржаргал
- 3.Рагчаагийн Бадамдамдин
- 4.Аюурзанын Базархүү
- 5.Батжаргалын Батбаяр

6. Шийлэгийн Батбаяр
7. Дашжамцын Баттулга
8. Цэвэлмаагийн Баярсайхан
9. Надмидын Баяртсайхан
10. Сангажавын Баярцогт
11. Соёлсүрэнгийн Билэгсайхан
12. Лувсанвандангийн Болд
13. Сэрээтэрийн Болдхэт
14. Адъяагийн Ганбаатар
15. Даваадоржийн Ганболд
16. Догсомын Ганболд
17. Галсанпунцагийн Ганхуяг
18. Сандагийн Гончиг
19. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун
20. Банзрагчийн Дэлгэрмаа
21. Дамдингийн Дэмбэрэл
22. Санжаасүрэнгийн Зориг
23. Самбуугийн Ламбаа
24. Луузангийн Лувсан-Очир
25. Үнэнбүрэнгийн Наранцэцэг
26. Рэнчинсамбуугийн Одонбаатар
27. Түвдэнгийн Очирхүү
28. Рэнцэнгийн Содхүү
29. Раздакийн Сандагхан
30. Таухейн Султан
31. Норжмаагийн Тогтох
32. Чүлтэмийн Улаан
33. Нямаагийн Түвшинтөгс
34. Цэвээндоржийн Төмөртоого
35. Должингийн Цогбадрах
36. Дониогийн Цогт-Очир
37. Мишигийн Чимэдцэрэн
38. Данзанбалжирын Энхтайван
39. Цагаандарийн Энхтүвшин
40. Төмөр-Очирын Эрдэнэбилэг
41. Ямааранзын Эрхэмбаяр

**5/ Хууль зүйн байнгын хороо**

1. Ёндонпунцагийн Адилбиш
2. Норовын Алтанхуяг
3. Саригийн Батчулуун
4. Соёлсүрэнгийн Билэгсайхан
5. Лувсанвандангийн Болд

6. Жамсрангийн Бямбадорж
7. Даваадоржийн Ганболд
8. Догсомын Ганболд
9. Очирбатын Дашбалбар
10. Банзрагчийн Дэлгэрмаа
11. Дамдингийн Дэмбэрэл
12. Мэндийн Зэнээ
13. Луузангийн Лувсан-Очир
14. Данзангийн Лүндээжанцан
15. Цэндийн Нямдорж
16. Чүлтэмийн Отгонбаяр
17. Чимэдийн Сайханбилэг
18. Сорогжоогийн Төмөр
19. Долгорын Хувьтөгөлдөр
20. Цэрэнхүүгийн Шаравдорж
21. Цахиагийн Элбэгдорж
22. Дамдинсүрэнгийн Энхбаатар
23. Ойдовын Энхтуяа
24. Төмөр-Очирын Эрдэнэбилэг

2. Монгол Улсын Их Хурлын Дэд хороодыг дараахь бүрэлдэхүүнтгээр байгуулсугай:

**1/ Ес зүйн дэд хороо:**

1. Норовын Алтанхуяг
2. Ёндонпунцагийн Адилбиш
3. Рагчаагийн Бадамдамдин
4. Шаравжамцын Батбаяр
5. Бат-Эрдэнийн Батбаяр
6. Даржаагийн Батнасан
7. Намдагийн Батцэрэг
8. Жамсрангийн Бямбадорж
9. Эрдэнийн Бат-Үүл
10. Сангажавын Баярцогт
11. Ажханы Болат
12. Адъяагийн Ганбаатар
13. Очирбатын Дашбалбар
14. Хэнмэдхэвийн Дашзэвэг
15. Мэндийн Зэнээ
16. Самбуугийн Ламбаа
17. Жамбын Норовсамбуу
18. Цэндийн Нямдорж
19. Чимэдийн Сайханбилэг
20. Радаагийн Сандагхан

21. Сорогжоогийн Төмөр
22. Долгорын Хувьтөгөлдөр
23. Төмөр-Очирын Эрдэнэбилэг

2/ Төсвийн зарлагын дэд хороо:

1. Ринчиннямын Амаржаргал
2. Рагчаагийн Бадамдамдин
3. Аюурзанын Базархүү
4. Дашжамцын Баттулга
5. Соёлсүрэнгийн Билэгсайхан
6. Цэвэлмаагийн Баярсайхан
7. Надмидын Баяртсайхан
8. Сангажавын Баярцогт
9. Цэрэндоржийн Ганхуяг
10. Санжаасүрэнгийн Зориг
11. Самбуугийн Ламбаа
12. Үнэнбүрэнгийн Наранцэцэг
13. Түвшэнгийн Очирхүү
14. Рэнцэнгийн Содхүү
15. Норжмаагийн Тогтох
16. Санжбэгзийн Төмөр-Очир
17. Ямааранзын Эрхэмбаяр

3/ Хүний эрхийн дэд хороо:

1. Шаравжамцын Батбаяр
2. Лувсанвандангийн Болд
3. Данзангийн Бохьцарга
4. Соёлсүрэнгийн Билэгсайхан
5. Жамсрангийн Бямбадорж
6. Банзрагчийн Дэлгэрмаа
7. Долгорын Хувьтөгөлдөр
8. Должингийн Цогбадрах
9. Дамдинсүрэнгийн Энхбаатар
10. Ойдовын Энхтуяа
11. Төмөр-Очирын Эрдэнэбилэг

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын И Хурлын 1996 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 11 дүгээр тогтоол хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1996 оны 8 дугаар  
арын 30-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар  
хот

**Суурь үнийг чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэрүүдийн санхүү, өрөнгийн чадварыг дээшлүүлэх, эрчим хүчний хангамжийн ийдвартай ажиллагааг хангах, энэ салбарт бий болсон өрийн дэвжээг арилгах шаардлагаг үндэслэн дараахь арга хэмжээ авч рэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /М.Энхсайхан/-г алгасугай:

1/ Түлш, эрчим хүчний үнийг Эрчим хүчний тухай "Монгол улсын хууль"-ийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасны гуу тогтоох, нийт үнийн тогтолцоог зах зээлийн зарчимд ийцүүлэх арга хэмжээ яаралтай авах;

2/ Эрчим хүчний салбарт зардал бууруулах, хэмнэлтийг амшуулах, жам ёсны монополийг зохицуулах зохион байгуулалтын тцийг бий болгох арга хэмжээ авах;

3/ Энэ тогтоолын 1 дэх хэсгийн 1-д заасантай холбогдуулан 1996 ы улсын төсөвт нэмэлт тодотгол хийх шаардлагатай гэж үзвэл налал энэ оны 10 дугаар сард багтаан Улсын Их Хуралд оруулах.

2. Энэ тогтоолыг 1996 оны 8 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн гаж мөрдөнө.

ДАРГА

**Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1996 оны 9 дүгээр  
сарын 3-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар  
хот

Төв Банк /Монголбанк/ -ны тухай  
хууль, "Банкны тухай хууль"-ийг  
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний  
тухай

"Төв Банк /Монголбанк/-ны тухай хууль", "Банкны тухай хууль"  
батлагдсантай холбогдуудан Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Мөнгө, зээлийн бодлого, банкны асуудлаар урьд гаргасан  
дүрэм, журам, зааврыг 1997 оны 3 дугаар сарын 31-ний дотор дээр  
хуульзудтай нийцүүлэх арга хэмжээ авахыг Монголбанк  
/Д. Молломжамц/-нд даалгасугай.

2. Банкны салбарт хэрэгжүүлэх бүтцийн өөрчлөлтийн аргыг  
хэмжээг боловсруулж, 1996 оны 11 дүгээр сард багтаан Улсын Их  
Хуралд танилцуулахыг Монголбанк /Д. Молломжамц/, Засгийн газар  
/М. Энхсайхан/-т даалгасугай.

3. Монголбанкны дүрэм батлах тухай Монгол Улсын Их Хурлын  
1993 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 34 дүгээр тогтоолыг 1996 оны  
10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДЭД ДАРГА

Ц. ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

196 оны 7 дугаар  
арын 05-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар  
хот

**Л. Идэрбатад Монгол Улсын  
гавьяат жүжигчин цол олгох  
тухай**

Морин хуур хөгжмийг гарамгай эзэмшин чадварлаг тоглохын рэгцээ бүжгийн болон дан хөгжмийн олон бүтээл зохион туурвиж суур урлагийн урын санг баяжуулан эх орныхоо соёл урлагийг даад орнуудад сургалчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ардын дуу бүжгийн чуулгын гоцлол хөгжимчин Лувсанмбын Идэрбатад Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

196 оны 7 дугаар  
арын 05-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар  
хот

**Л.Чудуунчимэгт Монгол Улсын  
гавьяат жүжигчин цол олгох  
тухай**

Ардын дууны баялаг сангаас бүтээлтээр суралцан олон арван уг өвөрмөц шинэ арга маягаар мэргэжлийн өндөр төвшинд дуулан он түмний талархал хүлээж Монголын радиогийн дуу хөгжмийн ган санг баяжуулан ардын дууг дуулах урлагийг хөгжүүлэхэд уулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Орхон аймгийн дуу бүжгийн "рдэнэт" чуулгын гоцлол дуучин Лувсандагвын Чулуунчимэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар  
хот

**А. Энхтайванд Монгол Улс  
гавьяат жүжигчин цол олгох  
тухай**

Дуу, хөгжим, кино урлагт авьяас билгээ сорьж урын санг байнга баяжуулан үндэсний болон сонгодог дуурийн олон дүрүүд амжилттай тоглохын зэрэгцээ нийтийн дууны дөч гаруй ая зохио Монголын кино дэлгэцэнд анх удаа Чингис хааны дүрийг бүтэс туурвиж дуурь, кино урлагийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрин нь үнэлж Сонгодог урлагийн академик театрын гоцлол дуучи Агваанцэрэнгийн Энхтайванд Монгол Улсын гавьяат жүжигчи цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАЯ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар  
хот

**Цэргийн цолны зэрэглэлд нэмж  
тайлбар оруулах тухай**

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1-д Зэвсэгт хүчин, бусад цэргийн ерөнхий удирдлагыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, 23 дугаар зүйлийн 1-д цэргийн мэргэжлийн удирдлагыг Зэвсэгт хүчин Ерөнхий штаб хэрэгжүүлэхээр заасныг иш үндэс болгон:

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдаар цэргийн бус хичээл томилуулах тухай Ерөнхий сайдын саналыг зөвшөөрч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн дугаар зарлигаар баталсан "Дээд офицерийн албан тушааль

гилал, цэргийн цолны зэрэглэл"-ийн 1-д "дэслэгч генерал-рандаа генерал" гэсний дараа "/энэ зэрэглэл цэргийн бус хүнд маарахгүй/" гэсэн нэмэлт тайлбар оруулсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1996 оны 5 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлө  
оруулах тухай Монгол Улсын  
хуулийн зарим заалт үндсэн хуули  
зөрчсөн эсэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг 19  
оны 5 дугаар сарын 23-ны өдөр 12 цагт зөвлөлдөх тасалгаа  
/гөрийн ордны 251 тоот өрөө/ үйлдэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцн  
гишүүн Л.Баасан даргалж гишүүн Ж.Бямбаа, С.Жанца  
Д.Чилхаажав, Ж.Бямбажав нарын бүрэлдэхүүнтэй, Цэцийн нарий  
бичгийн дарга Б.Цэндээхүүг оролцуулан хийв. Цэцийн хуралдаа  
гомдол гаргагч Д. Чулуунжав оролцоогүй бөгөөд Улсын Их Хурли  
итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Бямбадорж, О.Шаалуу нар оролцов.

Монгол Улсын иргэн Д.Чулуунжав Үндсэн хуулийн цэц  
хандаж гаргасан өргөдөлдөө "Одоо мөрдөгдөж байгаа парламент  
сонгуулийн хууль нарийн авч үзвэл ихээхэн дутагдал, соготг  
байна.

Улсын үндсэн хууль зөрчсөн заалт 4 бас оржээ... Нэр дэвшигч  
хүмүүсээс хэнийг ч сонгох хүсэлгүй иргэдийн саналын хуудса  
хүчингүйд тооцох нь тэр хүний сонгуулийн эрхийг хассантай иж  
юм. Ийм тохиолдолд сонгогч саналын хуудсаа огт тэмдэглэхгүйгэ  
хайрцганд хийх үү, эсвээс нэр дэвшигчийн нэрсийг дарах уу гэдги  
хуулиар тогтоосон байх ёстой...Татгалзсан санал бүхий хуудса  
хүчингүй хуудсанд тооцож хасаад байвал нэр дэвшигчийн авс  
саналын хувь, хэмжээ захирамгаар өсөх болно... Сонгуульд оролцс  
л бол заавал хэн нэг хүний төлөө саналаа өгөх ёстой гэ  
сонгогчийг шахаж болохгүй. Үндсэн хуульд заасан "Чөлөөтэй гэд  
зарчмын нэг тал нь эс сонгох эрх чөлөө мөн. ... Ингэхлээр бүр  
татгалзсан саналыг хүчингүйд тооцсон заалтын талаар ул үндэст  
дахин бодож үзээд түүнийг хүчинтэй саналд тооцохоор хуульчи  
УИХ-ын сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж өгөхийг...хүсье" гэж  
Өргөдөл гаргагч иргэн Д.Чулуунжав бичгээр ирүүлсэн тайлбарта  
Бүх нэр дэвшигчийн хувьд татгалзсан санал өгч болохгүй гэх юм  
эсвээс заавал хэн нэгийг нь дэмжиж санал өг гэж сонгогчид  
шахаж болохгүй.Ингэхлээр 36 дугаар зүйлийн 3-т байгаа "Санал о

эмдэглээгүй” хуудсыг хүчингүйд тооцох тухай заалт сонгогчийн энгэх ба эс сонгох эрх,үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т илгдсэн сонгогчийн чөлөөтэй сонголт хийх эрхийг зөрчиж байна.” гэж дурдсаны зэрэгцээ жишээ болгон тайлбарлахдаг.

“Ерөнхийлөгчийн сонгуульд 1 хүний нэр дэвшжээ ... Ийм хиолдолд татгалзсан саналыг хүчингүйд тооцвол ... ердөө 3-хан дний санал авсан ч 100 хувийн санал авснаар тооцогдох болно. атгалзсан санал, хүчингүй санал, хүчингүй саналд тооцогдох юмд иргэдийг харагтун” гэжээ.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Бямбадорж, О.Шаалуу нар Үндсэн хуулийн Цэцэд хандан бичгээр ирсэн тайлбартаа: “Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар йлийн 9 дэх хэсэгт “Монгол Улсын иргэд төрийн байгууллагад нгох сонгогдох эрхтэй. 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын х Хурлын гишүүнийг ... сонгоно” гэж заасан байна. Эдгээр нь нгуулийн үндсэн зарчим, Нэр дэвшүүлэн сонгох нь сонгуулийн с нэг чухал зарчим байдаг билээ. ...Нэр дэвшээгүй хэнийг ч нгодоггүй чухамхүү энэ утгаар нь сонгогч нэр дэвшигдсэн мүүсээс аль нэгийг нь сонгох ёстой. Хэрэв эдгээр нэр шигчийн хэнийг нь ч сонгох хүсэлгүй байвал сонгуульд олохгүй байх, эсхүл сонгуулийн хуульд заасны дагуу хуудас чингүй болох ёстой.

2. Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан лөөтэй сонгох зарчим нь дараах механизмаар хэрэгжинэ. Үүнд:

а. Сонгуульд оролцох эсэх нь тухайн иргэний хүсэл зоригийн рэг.

б.Саналаа гаргахад нь нууцыг алдагдуулахгүй, ямар нэгэн йлээр шахалт үзүүлэхгүй байхыг хэлнэ” гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Шаалуу, Бямбадорж нар Цэцийн хуралдаанд тайлбарлахдаг: “Чөлөөтэй” рэг нь иргэдийг сонгуульд оролцоход нь ямар нэгэн дарамт халт үзүүлж болохгүй гэсэн утга болно. Гэхдээ энэ бол ямар нэг нь хүний өмчилсөн дархан эрх бишээ.

Аливаа эрх бол ухаалаг хязгаарлалттай байдаг. Сонгуулийн хуульд э мэг хязгаарлалтыг тогтоожээ. Иймд Улсын Их Хурал хуулиар тгдсэн эрхийнхээ дагуу сонгуулийн журмыг хуулиар тогтоосныг дсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна гэжээ.

#### ХЯНАВАЛ:

Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт,өөрчлөлт оруулах ай Монгол Улсын 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн тлийн 1 дүгээр зүйлийн 5/36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн нал огт тэмдэглээгүй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн

хуулийн 21 дүгээр зүйлийн 2-г заасан "чөлөөт" гэсэн сонгуулийн зарчмыг зөрчжээ. Иймд иргэн Д.Чулуунжавын гомдлыг ханг үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдалага болгон ДҮГНЭЛТ гарганы:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэл өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн дахь хэсгийн "санал огт тэмдэглээгүй бол ... саналын хуудсыг хүчингүйд тооцно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчжээ.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хянан хэлэлцэж энэ тухай хариуг ирүүлэхийг Улсын Их Хурал уламжлав.

ДАРГА  
ГИШҮҮД

Л.БААСАН  
Ж.БЯМБАА  
С.ЖАНЦАН  
Ж.БЯМБАЖАВ  
Д.ЧИЛХААЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 8 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар  
хот

### Үнэ чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн "Суурь үнийг чөлөөлөх тухай" 39 тоот тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төвийн районы нүүрсний уурхайнуудаас олборлож буй нүүрсний үнийг 1996 оны 9 дүгээр сарын 1-нээс дунджаар 45 хувиар, Төвийн эрчим хүчний системээр дамжуулан борлуулж буй ахилгаан, дулааны үнийг 1996 оны 9 дүгээр сарын 10-наас дунджаар 60 хувиар, Нефть импорт концерн (төрийн өмч ивэмжлэгдсэн) хувьцаат компанийн нефтийн бүтээгдэхүүний үнийг 1996 оны 9 дүгээр сарын 1-нээс шатахууны нэр төрөл, бүс нутгаас хамааруулан дунджаар 29-60 хувиар нэмэгдүүлэн тогтоож өрдүүлсүгэй.

2. Нефтийн бүтээгдэхүүний үнийг дэлхийн зах зээлийн үнэ цэнэ төгрөгийн чөлөөт валюттай харьцах ханшны өөрчлөлттэй хамааруулан тухай бүр өөрчлөн зохицуулж байхыг "НИК" хувьцаат компани (Ж.МАНЬБАДАР)-д даалгасугай.

3. "Эрчим хүчний тухай" Монгол Улсын хуулийн дагуу нүүрс, ахилгаан, дулааны үнийг цаашид зах зээлийн зарчимд нийцүүлэн өөрчилж ажиллахыг Дэд бүтцийн хөгжлийн яам (Г.НЯМДАВАА)-д даалгасугай.

4. Үнэ чөлөөлж байгаатай уялдан төвлөрсөн болон орон нутгийн сөвт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэртэй талаар Монгол банктай хамтран ажиллахыг Сангийн яам (П. ЦАГААН)-д даалгасугай.

5. Үнэ чөлөөлж байгаатай холбогдуулан хүн амын амьжиргааны бийрвэл тодорхой хэмжээгээр хамгаалах зорилгоор төвийн эрчим хүчний системээр нэг өрхөд борлуулж байгаа 100 киловатт цагийн хилгааныг (1997 оны 5 дугаар сарын 10 хүртэлх хугацаанд) учин үнээр, түүнээс дэвсэн болон тоолуургүй хэрэглэгчийн рөглэсэн ахилгааныг шинэ үнээр тооцож байхаар тогтоосугай.

6. Түлш, эрчим хүчний үйлдвэрүүд болон нефтийн бүтээгдэхүүнийг импортлогч байгууллагуудын үйлдвэртэй, борлуулалтын зиллагааны зардлыг багасгах, нэгжийн өөрийн өртгийг хямдруулах, иваа үргүй зардлыг арилгахад чиглэсэн удирдлагын бүтэц, зохион

байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хөдөө аж ахуй үйлдвэрийн яам (Л.НЯМСАМБУУ), Дэд бүтцийн хөгжлийн яам (Г.НЯМДАВАА)-д тус тус даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Комисс байгуулах тухай Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 222 дугаа тогтоол, "Үнийн зөвшилтийн комисс байгуулах тухай" 1995 оны дугаар сарын 22-ны өдрийн 24 дүгээр тогтоолыг тус тус хүчингү болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Сангийн сайд

П.ЦАГААН

Хөдөө аж ахуй,  
үйлдвэрийн сайд

Л.НЯМСАМБУУ

Дэд бүтцийн хөгжлийн  
сайд

Г.НЯМДАВАА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 9 дүгээр  
сарын 5-ны өдөр

Дугаар 228

Улаанбаатар  
хот

Хувьчлах объектын жагсаал  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн зарим орон сууцны барилгуудын нэгдүгээ давхарт байрлаж байгаа үйлчилгээний байруудаас 1996 онд багтаа эхний ээлжинд дуудлагаар /бэлэн мөнгөөр/ хувьчлах байрууды жагсаалтыг 1 дүгээр хавсралтын ёсоор, мөн энэ онд багтаа дуудлагаар /бэлэн мөнгөөр/ хувьчлах улсын үйлдвэрийн газр болон бусад барилга байгууламжийн жагсаалтыг 2 дугаар хавсралты ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийслэлийн зарим а ахуйн нэгжүүдийн төрийн өмчийн оролцоог хувьчлах, зарим объектуудыг худалдах тухай" Монгол Улсын Засгийн газрын Өм хувьчлалын комиссын /хуучин нэрээр/ 1995 оны 7 дугаар сары 24-ний өдрийн 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтал дурдса

Төсөл шалгаруулж бэлэн мөнгөөр худалдах газруудын жаг  
валт"-ын 5,7-д заасныг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

М.ЭНХСАЙХАН

П.ЦАГААН

Зэсгийн газрын 1996 оны 228 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БАРИЛГУУДЫН  
НЭГДҮГЭЭР ДАВХРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИУ-  
ЛАЛТАЙ БАЙРУУДААС ДУУДЛАГААР БЭЛЭН  
МӨНГӨӨР ХУВЬЧАХ ЖАГСААЛТ

№	Дүүрэг	Хороололт	ОСА квентор	Байрны дугаар	Түрээслэж буй аж агууны нэвгж	Одоогийн ашиг- лаж буй зориулалт
1.	Баянзүрх	ХШ	6	1	"Соёл амьтас"	көтө дүрс бичлэ- гийн үйлчилгээ
2.	".."	".."	6	3	"Ундармаг" ХХК	худалдаа
3.	Чингэл- тэй-уул	1-р 40-н мөнгөл	16	7	"Хөшөө дэлгэ- рэн" ХХК	худалдаа
4.	".."	".."	16	7	"Тээт" нөхөрлөл	худалдаа
5.	".."	".."	16	7	"ЭГЭОДУС" ХХК	худалдаа
6.	".."	".."	16	7	"Гоо марал" ХХК	худалдаа
7.	".."	".."	16	7	"Баянзүрх хайрхан" ББХХ	юстицийн хөөр
8.	".."	".."	16	7	"Цэнгэ гүн" ХХК	худалдаа
9.	".."	".."	16	4	"Өгөөмөр-20" ББХХ	худалдаа
10.	".."	".."	16	3	"Тэрүүн мин- дал" ХЭАА	үсчмн, гоо зорил
11.	".."	".."	16	3	"Ном эрдэнэ" ХХК	худалдаа
12.	".."	".."	17	"Мэргэ- жилтэний 100"	"Угалз хайр- хан" ХХК	худалдаа
13.	".."	Бага говьсүх	2	9	"Хан-уул" ХХК	худалдаа
14.	Сүхбаатар	".."	3	2	"Оч хангад" ХХК	худалдаа

Засгийн газрын 1996 оны 228 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

**ДУУДЛАГААР БЭЛЭН МӨНГӨӨР ХУВЬЧЛАХ  
УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР БОЛОН БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

1. Улсын их дэлгүүр /УҮГ/
2. "Хангай" зочид буудлын баруун талын залгаа үйлчилгээний  
вийн барилгыг түрээсээр эзэмшиж буй дараахь аж ахуйн  
гжүүдийн байрлаж байгаа барилга байгууламж. Үүнд:
  - а/ "Монсоник групп" ХХК-ийн бизнес клуб
  - б/ "Тэса" ХХК
  - в/ "Солонго" ХХК
  - г/ "Анхилуун" ХХК

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л. Цог
Нарийн бичгийн дарга	Сан. Жаргалсайхан
Гишүүд	Б. Цэндлоо Ч. Бавуу Б. Ганбат Б. Янжилхам
Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан Б. Янжилхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1996 оны 10-р сарын 29-нд  
Өрөлтөд 1996 оны 11-р сарын 4-нд. Хэвлэлтэд  
1996 оны 11-р сарын 29-нд. Хэвлэлийн хуудас 6,5.  
Хэвлэсэн тоо 4250.

Манай хаяг: Улаанбаатар-12  
Төрийн ордон. Утас 322838

Төр, засгийн Үйлчилгээ аж ахуйг  
эрхлэх газрын харьяа  
хэвлэх үйлдвэр